

## Бүлэг 2



## 2. Татварын ногдлыг жишгээр тодорхойлох арга

### 2.1 Татварын ногдлыг жишгээр тодорхойлох аргын зорилго

Энэ бүлэгт татварын ногдлыг жишгээр тодорхойлох аргачлалыг боловсруулж оруулав.

Монгол улсын одоогийн Хүн амын орлогын албан татвар, Аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татвар, Нэмэгдсэн өртгийн албан татвар нь тайлан гаргаж татвараа төлөх тогтолцоотой бөгөөд ажил үйлчилгээ эрхэлж буй татвар төлөгч орлого зарлагаа тэмдэглэсэн данс бүртгэлд үндэслэн өөрөө татвар ногдох орлого болон татвараа тодорхойлон төлдөг.

Гэсэн хэдий ч бодит байдал дээр бүх татвар төлөгчдөөс данс бүртгэлд тусгасан бодит тоон дээр тулгуурлан татвараа тодорхойлохыг шаардахад хүндрэлтэй байна.

Нөгөө талаас бүх татвар төлөгчид хуулийн дагуу татварын тэгш ачааллыг үүрэх явдал нь татварын гол зарчим учраас данс бүртгэл байхгүйн улмаас орлогыг нь зөв тодорхойлж чадахгүй гэсэн шалтгаанаар татвар ногдуулахгүй байх нь данс бүртгэлд тулгуурлан татварын тайлангаа зүй зохистой гаргаж буй бусад татвар төлөгчидтэй адил тэгш байх зарчмын үүднээс аваад үзсэн ч байж болшгүй зүйл гэдэг нь тодорхой.

Татварын ногдлыг жишгээр тогтоох гэдэг нь данс бүртгэл байхгүйн улмаас орлогыг нь зөв тодорхойлох боломжгүй тохиолдолд ямар нэгэн шууд бус материалд тулгуурлан орлогыг нь тодорхойлох явдал бөгөөд зүй зохистой адил тэгш татвар ногдуулах үүрэгтэй татварын албаны хувьд татварын ногдлыг жишгээр тодорхойлох нь түүний эрхээс гадна үүрэг гэж хэлж болно.

Татварын байцаагч тайлан үл гаргагч болон багасгаж гаргагчдыг шалгахдаа тэдгээрийн ажил гүйлгээтэй холбогдолтой данс бүртгэл, анхан шатны бүртгэл зэрэг баримт материал байхгүй тохиолдолд уг татвар төлөгч этгээдээс асууж танилцах, харилцагч талыг нь хянан шалгах, холбогдох байгууллагаас авсан мэдээ материалд тулгуурлан орлого, зарлагыг нь тогтоосноор үйл ажиллагааны ашгийг нь тодорхойлох зэрэг үйл ажиллагааг явуулж байна.

Гэсэн хэдий ч татварын ногдлыг жишгээр тогтоосон үед шүүхэд гомдол гарган шүүх татварын албаны шийдвэрийг хүчингүй болгох явдал их гардгийг хайхрахгүй байж болохгүй. Үүнд хэд хэдэн шалтгаан байгаагаас хамгийн гол нь татварын ногдлыг жишгээр тогтоох зайлшгүй шаардлагыг батлах баталгаа, бодит баримтанд тулгуурласан жишгээр татвар ногдуулах нь оновчтой гэдгийг батлах баримт хангалтгүй байгаа явдал гэж бодож байна.

«Татварын ногдлыг жишгээр тодорхойлох арга» гэсэн энэ бүлэг нь дээрх байдлаас гарахын тулд жишгээр татвар ногдуулахад хэрэглэх тодорхой

аргачлалыг системтэйгээр цэгцэлж, хүн амын орлогын албан татвар, аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татвар, нэмэгдсэн өртгийн албан татвар зэрэг орлогыг тодорхойлоход шаардлагатай татвар ногдуулалтын ажлын практикт ашиглаж болох зүйлийг толилуулж байна.

Мөн энэ гарын авлагад дурьдсан аргууд нь орлогыг тодорхойлох ерөнхий аргууд учраас тэдгээрийг тэр хэвээр нь хэрэглэж болно гэсэн үг биш гэдгийг анхаарна уу. Тиймээс бодит байдал дээр хяналт шалгалтын байцаагч жишгээр орлогыг тодорхойлохдоо гарын авлагад заасан аргуудаас санаа аван өөрөө хамгийн оновчтой, бодитой аргыг боловсруулж гаргах хэрэгтэй.

Цаашид энэ гарын авлагыг Монгол улсын байдалд тохируулан, практик дээр тохиолдсон жишээн дээрээ тулгуурлан нэмж хасан илүү сайн гарын авлага боловсруулна гэдэгт найдаж байна.

## **2.2 Татвараа өөрөө тодорхойлох систем ба татварын ногдлыг жишгээр тодорхойлох**

### **2.2.1 Татвараа өөрөө тодорхойлох системд хамаарах заалт**

Татварын ерөнхий хуулийн 9 дүгээр зүйлийн (татвар төлөх журам) 1 дүгээр хэсэгт «татварыг татварын тайлан буюу орлого, татвар тодорхойлох хуудсаар, эсхүл суутгал хийх замаар ногдуулна.....», 10 дугаар зүйлийн 2 дугаар хэсэгт «татвар ногдуулах, төлөхтэй холбогдсон тооцоо, мэдээ тайланг тогтоосон хугацаанд татварын албанд ирүүлэх», 3 дугаар хэсэгт «анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг тогтоосон журмын дагуу хөтөлж, санхүү аж ахуйн үйл ажиллагааны тайлан тэнцэл гаргах» гэж заасан байдаг.

Мөн процессын хуулийн 8 дугаар зүйлийн (татвартай холбогдсон баримт бүрдүүлэх, бүртгэл хөтлөх, хадгалах) 1 дүгээр хэсэгт «татвар төлөгч нь хууль тогтоомжийн дагуу татвар ногдох зүйл, төлөх татварын хэмжээг тодорхойлохтой холбогдсон баримтыг бүрдүүлж, аж ахуйн нэгж байгууллагын тухайд нягтлан бодох бүртгэл, иргэний хувьд энгийн бүртгэл хөтөлнө », 15 дугаар зүйлийн (төлбөл зохих татварын ногдлыг тодорхойлох, бүртгэх, барагдуулах) 1 дүгээр хэсэгт «татвар төлөгч холбогдох баримт, бүртгэлд үндэслэн татварын ногдлоо өөрөө тодорхойлон татварын тайланд тусгана » гэж заасан байдаг.

Ийнхүү аж ахуйн нэгж, байгууллага болон хүн амын орлогын албан татвар нь зарчмын хувьд татвар төлөгч өөрөө анхан шатны болон нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлан зэрэг бусад холбогдох бичиг баримтанд тулгуурлан татвар ногдох орлого болон татварын хэмжээг тодорхойлж орлого тодорхойлох хуудсанд тэмдэглэн татварын албанд өгч татвараа төлөхөөр заасан байдаг.

Өөрөөр хэлбэл, аж ахуйн нэгж, байгууллага болон хүн амын орлогын албан татварт татвар төлөгч өөрөө татвараа тодорхойлох систем вйлчилдэг.

## 2.2.2 Татварын ногдлыг жишгээр тодорхойлох тухай заалт

Нөгөө талаар ТЕХ-ийн 24 дүгээр зүйлийн (үндэсний татварын алба, татварын улсын байцаагчийн бүрэн эрх) 1 дүгээр хэсгийн 2-т «анхан шатны болон нягтлан бодох бүртгэл хөтлөөгвйгээс орлого, зарлагыг нь тодорхойлох боломжгвй татвар төлөгчид хуульд заасан жишгээр татвар ногдуулах», процессын хуулийн 15 дугаар зүйлийн (татварын ногдлыг тодорхойлох хянан шалгах) 1 дүгээр хэсэгт «татвар төлөгч татварын ногдлыг буруу тодорхойлсон гэж үзвэл Татварын алба, байцаагч шалган тогтооно», уг зүйлийн 2 дугаар хэсэгт «татвар төлөгч хуульд заасан хугацаанд татварын тайланг тушаагаагвй буюу тушаасан боловч түүнд татварын ногдлыг тусгаагвй бол Татварын алба, байцаагч өөрт байгаа мэдээ баримтанд тулгуурлан тодорхойлох, шалгах, жишгээр ногдуулах үндсэн дээр татварын ногдлыг тодорхойлно», уг хуулийн 17 дугаар зүйлийн «татварын ногдлыг жишгээр тодорхойлох» 1 дүгээр хэсэгт «вйлдвэрлэл, вйлчилгээ явуулж байгаа болон явуулж байсан нь нотлогдож байгаа боловч вйл ажиллагааныхаа баримтыг бүрдүүлээгвй, бүртгэл хөтлөөгвй буюу дутуу хөтөлсөн, эсхүл баримт бүртгэл татварын тайланг гаргаж өгөөгвй тохиолдолд тухайн татвар төлөгчийн татварын ногдлыг Татварын алба жишгээр тодорхойлно», уг зүйлийн 2 дугаар хэсэгт « татвар төлөгчтэй ойролцоо хүчин чадал, нөхцөл бүхий адилтгах вйлдвэрлэл вйлчилгээг тухайн орон нутагт эрхэлж буй татвар төлөгч байгаа бол түүний, байхгвй бол ойролцоо орон нутагт орших хэд хэдэн татвар төлөгчийн вйлдвэрлэл, вйлчилгээний хэмжээ, орлого зарлагын буюу бусад бодит тооцоонд үндэслэн татварын хэмжээг тогтоохыг татварын ногдлыг жишгээр тодорхойлох гэнэ. Уг татвар төлөгч нь тухайн вйлдвэрлэл, вйлчилгээг татвар ногдуулах хугацаанаас өмнөх дараалсан хоёр жилд явуулж байсан бол түүний тийнхүү вйлдвэрлэл вйлчилгээ явуулж байсантай холдбогдох баримт, бүртгэл тооцоонд үндэслэн татварын ногдлыг тодорхойлж болно» гэж заасан байдаг.

Мөн хүн амын орлогын албан татварын хуулийн 5 дугаар зүйлийн (татвар ногдох орлогыг тодорхойлох) 2 дугаар хэсэгт заасан «хувиараа ажил вйлчилгээ эрхлэгчдийн татвар ногдох орлого»-ын дараагийн мөрөнд «татвар ногдох орлого нь тодорхой бус, эсхүл тодорхойлох боломжгвй тохиолдолд байгаль, цаг уур, хотын адил нөхцөл бүхий татвар төлөгчийн адил төрлийн вйлдвэрлэлтэй харьцуулж Татварын алба татварын ногдлыг тодорхойлно» гэж заасан байдаг.

Өөрөөр хэлбэл, энэхүү заалт нь аж ахуйн нэгж, байгууллага болон хувиараа ажил вйлчилгээ эрхлэгч бүртгэл тооцоо хөтөлдөгвй, эсхүл хагас дутуу хөтөлдөг, орлогыг нь тодорхойлоход шаардлагатай төлбөрийн баримт, квитанци, бүх төрлийн гэрээ контракт, тэмдэглэл зэрэг нотолгоо болох баримт материал (хойшид анхан шатны тэмдэглэл гэх) байхгвйгээс болж тухайн татвар төлөгчийн орлого, ажил вйлчилгээний орлогыг бодит

тооцоон дээр тулгуурлаж тодорхойлох боломжгүй тохиолдолд уг татвар төлөгчтэй ойролцоо нөхцөлд адилтгах вйлдвэрлэл, вйлчилгээ эрхэлдэг тухайн бvс нутаг дахь татвар төлөгчтэй харьцуулах замаар татварын ногдлыг жишгээр тодорхойлох тухай заасан заалт юм.

Дээрх заалт нь нягтлан бодох бүртгэл хөтөлдөггvйн зэрэгцээ аж ахуйн вйл ажиллагаанд хамаарах анхан шатны бүртгэл тооцооны баримтгvй татвар төлөгчийн орлогыг тодорхойлоход хvндрэлтэй вeд бусад татвар төлөгчтэй харьцуулах замаар аргаар татварын тооцоо хийх эрхийг татварын албанд олгосон заалт юм.

Энэ нь татвар төлөгч өөрөө татварын тооцоогоо хийж тайлан гаргадаг тогтолцоо хэрэгжиж байгаа вeд орлого тодорхойлоход шаардлагатай нягтлан бодох бүртгэл байхгvй гэдэг шалтгаанаар адил татвар ногдлуулах нь татварын эрх тэгш байх зарчимд вл нийцэх ба татварын ногдлыг тодорхойлохтой холбогдох татварын албаны эдлэх ёстой мэдээжийн эрхийн тухай тусгасан заалт юм.

Дор аж ахуйн вйл ажиллагааны орлого зарлагын баримт бүртгэлийн бодит тооцоонд (хойшид «бодит хэмжээ»гэх) тулгуурлаж шууд аргаар орлого тодорхойлохыг «бодит татвар ногдуулалт», вvний эсрэг бусад татвар төлөгчтэй харьцуулах дам аргаар орлого тодорхойлохыг «татварын ногдлыг жишгээр тодорхойлох» гэж взнэ.

### **2.3 Татварын ногдлыг жишгээр тодорхойлох тухай журам**

Дээр 2.2-т өгүүлсэн Татварын ерөнхий хууль, процессын хууль, аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татварын хууль, хүн амын орлогын албан татварын хуулинд заасан татварын ногдлыг жишгээр тодорхойлох тухай заалтын дагуу татварын ногдлыг жишгээр тодорхойлох аргачлалыг тодорхойлсон YTEГ-ын даргын тушаал гарсан (1996 оны 9 сарын 3-ны өдрийн YTEГ-ын даргын 98 тоот тушаалын 2 дугаар хавсралт «Татварын ногдлыг жишгээр тодорхойлон хураах журам»).

Энэ журамд ажил вйлчилгээ эрхлэгч баримт бүртгэлгvй, эсвэл зохих журмын дагуу бүртгэл хөтлөөгvй тохиолдолд татварын ногдлыг жишгээр тодорхойлох тухай заасан ба дор дурдсан гурван аргыг дурдсан байна.

- ① Тухайн татвар төлөгчтэй ойролцоо хvчин чадал, нөхцөл бvхий адилтгах вйлдвэрлэл, вйлчилгээг тухайн орон нутагт эрхэлж буй татвар төлөгч байгаа бол тvвний, байхгvй бол ойролцоо орон нутагт орших хэд хэдэн татвар төлөгчийн вйлдвэрлэл вйлчилгээний хэмжээ, орлого зарлагын буюу бусад бодит тооцоонд вндэслэх
- ② Уг татвар төлөгч тухайн вйлдвэрлэл, вйлчилгээг татвар ногдуулах хугацаанаас өмнөх дараалсан 2 жилд явуулж байсан бол тvвний тийнхvв вйлдвэрлэл вйлчилгээ явуулж байсантай холбогдох баримт, бүртгэл тооцоонд вндэслэх.
- ③ Ажлын зураг авалтаар татварын ногдлыг тодорхойлох

#### **2.4. Татварын ногдлыг жишгээр тодорхойлоход анхаарах зүйл**

Дээрх 2.2, 2.3-т татварын ногдлыг жишгээр тодорхойлон хураах ач холбогдол, үндэслэл, аргачлалын талаар холбогдох хууль тогтоомжинд тулгуурлан тайлбарласан бөгөөд энэ хэсэгт татварын ногдлыг жишгээр тодорхойлоход анхаарах ёстой зарим зүйлийн талаар дурдъя.

Татварын ногдлыг жишгээр тодорхойлох энэхүү аргаар татварын тооцоо хийх нь татвар төлөгчийн хувьд хамгийн боломжийн бөгөөд зохистой арга байх хэрэгтэй хэдий ч энэ арга нь тогтсоосон нэг янзын аргаар хязгаарлагдахгүй, 1-рт тухайн татвар төлөгч ямар төрлийн ажил үйлчилгээ эрхэлж буй, 2-рт шалгалтаар олж илрүүлсэн зүйл, 3-рт шалгалтаар ажил үйлчилгээний баримт бүртгэл, анхан шатны бүртгэл тэмдэглэл олж илрүүлсэн эсэхээс хамааран татварын ногдлыг жишгээр тодорхойлох аргууд ч янз бүр бөгөөд тухайн нөхцөл байдал болон бичиг баримтыг үндэслэн хамгийн оновчтой аргыг сонгох нь чухал юм.

Энэ тохиолдолд баримт, бүртгэлийн төрлүүдээс хамааран татварын ногдлыг жишгээр тодорхойлох арга ч гэсэн олон хувилбартай болох тул хяналт шалгалтын байцаагч дор дурдах татварын ногдлыг жишгээр тодорхойлох ерөнхий аргуудаас санаа аван аль болох бодит тооцоон дээр тулгуурласан аргыг боловсруулах нь зүйтэй.

Гэхдээ татварын ногдлыг жишгээр тодорхойлно гэдэг нь татварын тусгай хариуцлага хүлээлгэнэ, арга хэмжээ авна гэсэн хэрэг биш бөгөөд орлогын хэмжээг тогтоохдоо үйлдвэрлэл, үйлчилгээний орлого зарлагын бүртгэл, баримтанд шууд тулгуурлан явуулах уу (бодит татвар ногдуулалт), эсвэл бусад татвар төлөгчтэй харьцуулан жиших аргаар орлогыг тодорхойлж татвар ногдуулах уу (татварын ногдлыг жишгээр тодорхойлох) гэдэгт л татварын ногдлыг тодорхойлох арга барилын ялгаа орших бөгөөд бодит болон жишгээр тодорхойлох нь зөвхөн орлогын хэмжээг тогтоох аргаараа л хоорондоо ялгаатай.

Мөн ердийн татварын хяналт шалгалт явуулаад ч бодит татвар ногдуулалт хийх боломжгүй бол татварын ногдлыг жишгээр тодорхойлох арга хэрэглэхэд зайлшгүй хүрэх тул (Үүнийг жишгээр тодорхойлох зхйлшгүй нөхцөл гэнэ) татварын ногдлыг жишгээр тодорхойлоход ердийн хяналт шалгалтын арга барилыг сайжруулахад анхаарах хэрэгтэй .

#### **2.5 Орлогыг жишгээр тодорхойлох арга**

Дээр дурдсанчлан орлогын хэмжээг жишгээр тодорхойлохдоо татвар төлөгчийн ажил үйлчилгээний нэр төрөл, хяналт шалгалтаар илрүүлсэн баримт, бүртгэлд тулгуурлан тооцоолж болох аргуудын дундаас хамгийн оновчтой тохиромжтой аргыг сонгох хэрэгтэй байдаг. Эдгээр ерөнхий

аргуудаас дор авч үзье. Орлого тодорхойлох арга болон нэр томъёог дараах байдлаар авч үзэв.

Мөн орлогыг тодорхойлохын тулд юуны өмнө үйл ажиллагааны ашиг (Японд орлогын хэмжээ гэж хэлдэг)-ийг тооцох аргыг тодорхой болгохын хамт жишгээр тодорхойлоход хэрэглэх нэр томъёог тогтоох шаардлагатай. Ашгийг тооцох арга болон нэр томъёоны тухай ярьсны дараа татварын ногдлыг жишгээр тодорхойлох аргачлын тухай танилцуулъя.

### 2.5.1 Нийт орлого болон үйл ажиллагааны ашгийг тооцох арга

① борлуулалтын орлого — ②борлуулалтын өртөг = ③нийт ашиг  
(орлогын хэмжээ) (борлуулсан барааны өртөг)

③нийт ашиг — ④үйл ажиллагааны зардал = ⑤үйл ажиллагааны ашиг

(жич: үйл ажиллагааны зардал гэдэг нь борлуулалтын өртгөөс (худалдан авалтын дvн) бусад хуулинд заасан зардлуудыг (боловсон хvчний зардал, түрээсийн төлбөр, элэгдлийн зардал гэх мэт) хэлнэ.

### 2.5.2 Нэр томъёо

1) «Борлуулалтын өртгийн хувь хэмжээ» гэдэг нь борлуулалтын орлогод эзлэх борлуулалтын өртгийн хувийг хэлнэ.

Борлуулалтын өртгийн хувь хэмжээ = ②борлуулалтын өртөг ÷ ① борлуулалтын орлого

2) Нийт ашгийн түвшин гэдэг нь борлуулалтын орлогод эзлэх нийт ашгийн хувийг хэлнэ.

Нийт ашгийн түвшин = ③ нийт ашиг ÷ ① борлуулалтын орлого

3) Үйл ажиллагааны зардлын хувь хэмжээ гэдэг нь борлуулалтын орлогод эзлэх үйл ажиллагааны зардлын хувийг хэлнэ.

Үйл ажиллагааны зардлын хувь хэмжээ = ④үйл ажиллагааны зардал ÷ ① борлуулалтын орлого

4) Зардлын хувь хэмжээ гэдэг нь борлуулалтын орлогод эзлэх борлуулалтын өртөг болон үйл ажиллагааны зардлын нийлбэрийн хувийг хэлнэ.

Зардлын хувь хэмжээ = (②борлуулалтын өртөг+④үйл ажиллагааны зардал) ÷ ① борлуулалтын орлого

5) Үйл ажиллагааны ашгийн түвшин гэдэг нь борлуулалтын орлогод эзлэх үйл ажиллагааны ашгийн хувийг хэлнэ.

Үйл ажиллагааны ашгийн түвшин = ⑤ ашгийн хэмжээ ÷ ① борлуулалтын орлого



### 2.5.3 Жишгээр тодорхойлох аргууд

#### [1] Хувь тэнцүүлэх арга

Энэ нь татвар төлөгчийн орлого, зарлага, вйлдвэрлэлийн болон борлуулалтын хэмжээ зэрэг тоон үзүүлэлтэнд тодорхой хэмжээний хувь тэнцүү хэмжээгээр орлого тодорхойлох арга бөгөөд дараах дөрвөн төрөлтэй.

- 1) Адил төрлийн ажил, вйлчилгээ эрхлэгчийн ашгийн түвшинг ашиглан тооцоолох арга

Энэхүү адил төрлийн ажил, вйлчилгээ эрхлэгчийн ашгийн түвшинд тулгуурлан татварын ногдлыг жишгээр тодорхойлох арга нь тухайн татвар төлөгчтэй адил төрлийн вйл ажиллагаа эрхэлдэг бөгөөд вйл ажиллагааны хэлбэр, цар хүрээ, газар зүйн адил нөхцөл бүхий нэлээд хэдэн аж ахуйн нэгжийг (дор, «адил төрлийн вйл ажиллагаа эрхлэгч» гэх) сонгож (аль болох олон аж ахуйн нэгж сонгох хэрэгтэй бөгөөд хамгийн багаар бодоход 2-3 байх нь зохистой) эдгээр аж ахуйн нэгжийн борлуулалтын өртөг, нийт ашиг, зардал болон нийт ашгийн түвшин, нэг ажилтанд ногдох орлогын дундаж үзүүлэлтэнд тулгуурлан татварын ногдлыг жишгээр тодорхойлох арга юм.

(жич: энэ аргыг татвар төлөгчийн борлуулалтын орлого (дор дурдсан үр ашигт нь тулгуурлан татварын ногдлыг жишгээр тодорхойлох аргаар тооцож гаргасан борлуулалтын орлогыг үүнд хамруулна), худалдан авалтын хэмжээ, вйл ажиллагааны зардал зэргийн аль нэг нь тодорхой байгаа тохиолдолд хэрэглэх бөгөөд (энэ тохиолдолд борлуулалтын орлого, худалдан авалтын дүн, вйл ажиллагааны зардалд тулгуурлан тооцоо хийх бөгөөд эдгээр гурван үзүүлэлтийг «жишиг тооцооны багана» гэж нэрлэнэ) татварын ногдлыг жишгээр тодорхойлох энэ арга нь бодитой бөгөөд магадлал өндөртэй мөн татвар төлөгчид ойлгуулахад хялбар байдаг. Энэ арга нь УТЕГ-ын даргын тушаалд (Татварын ногдлыг жишгээр тодорхойлон хураах журам) заасан 2.3① арга юм.

Хувираа хөдөлмөр эрхлэгчийн орлогын хэмжээг жишгээр тодорхойлох үед адил төрлийн вйл ажиллагаа эрхлэгчийг сонгохдоо хувь хүн болон аж ахуйн нэгжийн орлогыг тодорхойлох аргын ялгааг харгалзан үзэж аж ахуйн нэгжийн орлогыг хувь хүний орлогод шилжүүлж тооцохын тулд дараах аргыг хэрэглэх нь зүйтэй.

Хувь хүний орлогод шилжүүлж тооцсон орлого = аж ахуйн нэгжийн татварын өмнөх орлого (ажил вйлчилгээний зардал доторх удирдах ажилтаны шагнал, урамшуулал болон ажилчдын цалин хөлс доторх захирал болон түүний гэр бүлд ногдох мөнгөний хэмжээ) + (зардалд багтах хүү, байрны зардлын өглөг доторх захирал болон түүний гэр бүлд ногдох мөнгөний хэмжээ) — (ашигт оруулж тооцсон захирал

болон түүний гэр бүлээс гаргуулж авсан тухайлбал түрээсийн зардал болон зээлийн хүүгийн орлого)

*Хувилбар аргууд*

- Татвар төлөгчийн борлуулалтын хэмжээг гол үзүүлэлт болгох тохиолдолд

Борлуулалтын орлого  $\times$  адил төрлийн ажил үйлчилгээ эрхлэгчийн дундаж нийт ашгийн түвшин = нийт ашиг

- Татвар төлөгчийн борлуулалтын өртгийг жишгээр тодорхойлох гол үзүүлэлт болгох тохиолдолд

Борлуулалтын өртөг  $\div$  адил төрлийн ажил үйлчилгээ эрхлэгчийн борлуулалтын дундаж өртгийн хувь хэмжээ = борлуулалтын орлого

- Татвар төлөгчийн үйл ажиллагааны зардлын хэмжээг гол үзүүлэлт болгох тохиолдолд

Үйл ажиллагааны зардлын дүн  $\div$  адил төрлийн ажил үйлчилгээ эрхлэгчийн дундаж зардлын түвшин = борлуулалтын орлого

Борлуулалтын орлого  $\times$  Адил төрлийн ажил үйлчилгээ эрхлэгчийн үйл ажиллагааны ашгийн түвшин = үйл ажиллагааны ашиг

(жич: адил төрлийн үйл ажиллагаа эрхлэгчийн хувь хэмжээгээр татварын ногдлыг жишгээр тодорхойлох жишээг 5 хэсгийн 2-р зүйлээс харна уу )

- 2) Орлого зарлага нь тодорхой мэдэгдэж байгаа өмнөх үеийн үйл ажиллагаатай харьцуулах арга

Тухайн татвар төлөгчийн үйл ажиллагаанд нь тулгуурлан татварын ногдлыг жишгээр тодорхойлох арга нь татвар төлөгчийн ① тодорхой хугацааны ажлын үр дүн болон баримт бүртгэл, ② хэсэгчилсэн тэмдэглэл, баримт бүртгэл, ③ өмнөх болон дараа оны баримт бүртгэл ажлын үзүүлэлт, хяналт шалгалтын үр дүн ④ бүртгэл тайланд тусгасанаас гадуурх мөнгөний хувь хэмжээ зэрэгт тулгуурлан олж тогтоосон борлуулалтын өртөг, нийт ашиг, үйл ажиллагааны зардал, орлогын хэмжээ, нэг ажилтанд ногдох гүйлгээний дундаж хэмжээ зэргийг тооцоолж (тухайн хvнд нь харьцуульсан хувь хэмжээ) орлогын хэмжээг жишиж тооцох арга юм. (жич: энэ аргыг татвар төлөгчийн тухайн оны болон өнгөрсөн оны бүртгэл тооцоо эсвэл арилжаа баримт бүртгэлд бичиг бүрэн бус ч гэсэн зарим нэг хэсэг нь тодорхой тохиолдолд хэрэглэнэ.

Жич: Гэхдээ өнгөрсөн оны бүртгэл тооцоог хэрэглэх тохиолдолд тухайн оны ажил үйлчилгээний нөхцөл болон вйлдвэрлэлийн хэв маягт онцын өөрчлөлт гараагүй тохиолдолд хэрэглэж болно. Тухайн хувь хvнд нь харьцуулах арга нь адил төрлийн ажил үйлчилгээ эрхэлдэг татвар төлөгчтэй харьцуулах аргаас илvv адилтгах шинж чанар өндөр тул оновчтой байдаг. Энэ нь YTEГ-ын даргын тушаалд (Татварын ногдлыг жишгээр тодорхойлон хураах журам) заасан 2.3② арга юм.

#### Хувилбар аргууд

- Өмнөх оны вйл ажиллагааны аль нэг үндсэн үзүүлэлтэнд (ус ашигласаны болон эрчим хvчний төлбөр гэх мэт) тулгуурлан тооцоолох тохиолдолд

(өмнөх оны орлого ÷ өмнөх оны үндсэн үзүүлэлт × тухайн оны үндсэн тоон үзүүлэлт) = тухайн оны орлого

Жишээ:

Өмнөх оны орлого 10,000,000 Tg ÷ өмнөх оны хэрэглэсэн усны хэмжээ 400 литр × тухайн оны хэрэглэсэн усны хэмжээ 500 литр = тухайн оны орлого 12500,000 Tg

Тодорхой хугацааны баримт бүртгэлд тулгуурлах тохиолдолд

- (татвар төлөгчийн тодорхой хугацаан дахь баримтаар нотлогдож буй борлуулалтын орлого) × (адил төрлийн ажил үйлчилгээ эрхлэгчийн жилийн борлуулалтын орлого/адил төрлийн ажил үйлчилгээ эрхлэгчийн тухайн тодорхой хугацаанд олсон борлуулалтын орлого) = тухайн татвар төлөгчийн жишгээр тооцсон жилийн борлуулалтын орлого

Жишээ:

Татвар төлөгчийн 1-4 сар хvртэлх борлуулалтын орлого 4,000,000 Tg × 12.000.000 Tg /3.000.000 Tg (адил төрлийн ажил үйлчилгээ эрхлэгчийн 1-4 сар хvртэлх борлуулалтын орлого 3.000.000 Tg-д жилийн борлуулалтын орлого 12.000.000 Tg –ийг харьцуулсан хэмжээ) = Тухайн жилийн борлуулалтын орлого 16,000,000 Tg

4,000,000 Tg × 12.000.000 Tg /3.000.000 Tg = 16,000,000 Tg

Татвар төлөгчийн тодорхой хугацааны борлуулалтын орлого) × (тухайн татвар төлөгчийн гол нэрийн бараа бүтээгдэхvн ((зардал)) – ний тухайн хугацаан дахь худалдан авалтын хэмжээ ((зардал))-г

100% гэж үзсэн тохиолдолд тухайн нэр төрлийн бүтээгдэхүүний ((зардал)) жилийн худалдан авалтын харьцуулсан хувь хэмжээ (зардал) = тухайн оны борлуулалтын орлого

(жич: тухайн татвар төлөгчийн зөвхөн тодорхой хугацааны борлуулалтын орлогыг л мэдэх буюу гол төрлийн бараа бүтээгдэхүүний жилийн худалдан авалтын хэмжээг мэдэж байх тохиолдолд энэ аргыг хэрэглэнэ)

Жишээ:

Татвар төлөгчийн 1-4 сар хүртэлх борлуулалтын орлого 5.000.000Тг  $\times$  3.000.000 Тг /1.000.000 Тг (хяналт шалгалтанд хамрагдсан татвар төлөгчийн гол нэрийн бүтээгдэхүүний 1-4 сар хүртэлх худалдан авалтын өртөг 1.000.000 Тг-д жилийн худалдан авалтын дүн 3.000.000 Тг-ийг харьцуулсан нь) = тухайн оны орлого 15,000,000Тг

3) Нийт ашгийн дундаж түвшинг тооцох арга

Энэ нь тухайн татварын албанд харъяалагдах адил төрлийн ажил, үйлчилгээ эрхлэх бүх татвар төлөгчийн орлого, зарлагын тооцоог нэгтгэн боловсруулж тухайн салбарын нийт ашгийн түвшинг тооцоолж гаргаад уг дундаж үзүүлэлтийг хяналт шалгалтанд ашиглан орлого жишгээр тодорхойлох арга юм.

Уг арга нь хийсвэр тооцоонд үндэслэдэг боловч бодит байдалд ойртуулахын тулд дундаж нийт ашгийн түвшинг тооцохдоо аль болох олон тооны татвар төлөгчдийн нийт ашгийн түвшинг салбар тус бүрээр тодорхойлдог ба бодит байдалд ойртуулахын тулд хяналт шалгалтаар залруулагдсан үзүүлэлтүүдийг тооцоонд ашиглах хэрэгтэй.

Иймд тухайн татварын алба урд өмнө хяналт шалгалтанд хамрагдсан адил төрлийн татвар төлөгчийн дундаж үзүүлэлтэнд хамаарах баримт материалыг боловсруулах хэрэгтэй байдаг.

Жишээ:

S Татварын албанд харъяалагдах 1999 онд хяналт шалгалтанд хамрагдсан бүх нийтийн хоолны газрын борлуулалтын хэмжээнд эзлэх нийт ашгийн түвшин (дундаж нийт ашгийн түвшин) 40% байв. Хяналт шалгалтанд хамрагдах R татвар төлөгчийн тухайн оны борлуулалтын орлого 30,000,000 Тг гэж үзвэл R татвар төлөгчийн тухайн оны нийт ашиг  $30,000,000 \text{ Тг} \times 40\% = 12,000,000 \text{ Тг}$  болж байна.

4) Орлогын дундаж хувь хэмжээнд тулгуурлан орлогыг тодорхойлох

Орлогын дундаж хувь хэмжээгээр татварын ногдлыг жишгээр тодорхойлох энэ арга нь бодит татвар ногдуулалтаар тогтоосон хяналт шалгалтын хэд хэдэн үзүүлэлт (үүнд тухайн татварын албанд харъяалагдах дүврэг төдийгүй нийт татварын албаны хяналт шалгалтын үзүүлэлт хамаарна)-нд тулгуурлах ба онцгой үзүүлэлтийг үл тооцон орлогын дундаж хувь хэмжээг (стандарт хэмжээ) тооцож гаргасан уг орлогын хувь хэмжээгээр орлого тодорхойлох арга юм.

(жич: орлогын дундаж хувь хэмжээнд тулгуурлах болон дундаж ашгийн нийт түвшинг тооцох арга нь зарчмын хувьд адилхан юм. Дундаж нийт ашгийн түвшинд тулгуурлах арга нь тухайн татварын албанд харъяалагдах татвар төлөгчдийн хүрээнд тогтоосон дундаж ашгийн түвшинг гаргадаг бол орлогын дундаж хувь хэмжээнд тулгуурлах арга нь нийт улсын хэмжээн дэхь ашгийн түвшинг тогтоодгоороо ялгаатай. Иймд нийт ашгийн түвшинд тулгуурлах арга нь тухайн бус нутгийн онцлогыг харгалзан үздэг тул орлогын дундаж хувь хэмжээнд тулгуурлах аргатай харьцуулахад бодит орлогын хэмжээнд ойр дөт тооцоо хийх боломжтой байдаг)

Энэ арга нь тооцооллын хувьд өмнөх аргатай адил ба улсын хэмжээнд салбар бүрээр нэг дундаж нийт ашгийн түвшинг ашигладаг. Улсын хэмжээнд тооцсон салбар бүрээрх нийт ашгийн түвшин нь нууц хаалттай үзүүлэлт бөгөөд түүнийг зөвхөн татварын хяналт шалгалтын зорилгоор ашиглах хэрэгтэй.

**[2] Үр ашгийн хувь хэмжээ (нэгжид оногдох хувиар тооцох тооны арга)-д тулгуурлан тодорхойлох арга**

Үр ашгийн хувь хэмжээгээр татварын ногдлыг жишгээр тодорхойлох арга нь татвар төлөгчийн ашиг, орлого, худалдан авалтын хэмжээ зэрэг үзүүлэлт тодорхой бус тохиолдолд аж ахуйн үйл ажиллагааны үндсэн үзүүлэлт эсвэл цар хүрээнд (арилжаа наймааны тоо, түүхий эдийн хэмжээ, ажилчдын тоо, тоног төхөөрөмж, цахилгаан болон усны төлбөр зэрэг нэг нэгжид хамаарах орлого) үндэслэн орлогыг тодорхойлох арга юм. Энэ тохиолдолд хувь тэнцүүлэх аргыг хавсран хэрэглэдэг.

(Жич: Тодорхой жишээг 2.5.4[1]-ээс харна уу.)

**[3] Хөрөнгө ба өр төлбөрийн өсөлт бууралтыг тооцох арга (цэвэр хөрөнгийг харьцуулах арга)**

Хөрөнгө ба өр төлбөрийн өсөлт бууралтыг тооцох арга нь орлого, зарлага, ашиг алдагдлын тооцоогоор бус [(улирлын сүүлийн хөрөнгө – улирлын эхний хөрөнгө) – (улирлын сүүлийн өр төлбөр – улирлын эхний өр төлбөр) + амьжиргааны зардал гэх мэт зардал – үйл ажиллагааны бус орлого = үйл ажиллагааны ашиг] гэсэн цэвэр хөрөнгийн өсөлт бууралтад тулгуурлан цэвэр ашиг, орлого тодорхойлох арга бөгөөд нягтлан бодох бүртгэлийн давхар бичилтийн системийн үндсэн зарчим ёсоор ашиг алдагдлын

тооцоонд үндэслэн өсөлтийн хэмжээтэй тохирох орлогыг тодорхойлох тул оновчтой арга гэж үздэг.

(жич: Энэ арга нь аж ахуйн үйл ажиллагааны ашиг огт тодорхойгүй вед ч гэсэн тухайн оны цэвэр хөрөнгийн өссөн дүн болон амьжиргааны зардал зэрэг ахуйн нийт зардлаас үйл ажиллагааны бус орлогыг хассан дүн нь аж ахуйн үйл ажиллагааны ашгаар санхүүждэг гэж үздэг. Энэ аргаар улирлын сүүл болон эхний үеийн хөрөнгө ба өр төлбөрийг тодорхойлоход хүндрэлтэй байдаг)

(Энэ аргаар тооцоо хийх жишээг 2.5.4[3]-ээс харна уу.)

#### **[4] Зардлын хэмжээгээр тодорхойлох арга**

Энэ нь хөрөнгө өр төлбөрийн нэмэгдэл, хорогдлын хэмжээгээр татварын ногдлыг жишгээр тодорхойлох аргын нэг төрөл бөгөөд татвар төлөгчийн хувийн амьжиргааны зардал болон бусад хувийн хэрэглээний зардлаас хөөн орлогын хэмжээг тодорхойлох арга юм.

Жич: Энэ арга нь хөрөнгө өр төлбөрийн хэмжээнд өөрчлөлт гараагүй бөгөөд аж ахуйн үйл ажиллагаанаас бусад эх үүсвэрээс хөрөнгийн урсгал орж ирээгүй тохиолдолд үйл ажиллагааны ашиг бага боловч зарим орлогоо амьжиргааны зардал болон бусад зардалд зарцуулсан байж болох магадлалтай гэж үздэг.

### **2.5.4 Татварын ногдлыг жишгээр тодорхойлох жишээ аргууд**

#### **[1] Vp ашгийн хувь хэмжээгээр борлуулалтын хэмжээг тодорхойлох**

Бүртгэл баримт, анхан шатны бүртгэлгүй тохиолдолд борлуулалтын орлого, худалдан авалтын өртөг, үйл ажиллагааны зардлын хэмжээг тодорхойлохдоо тухайн татвар төлөгч болон ажилчдаас нь асууж лавлах, бэлэн байгаа бүтээгдэхүүний тоо ширхэг, үнийг тогтоож харилцагч байгууллага болох худалдан авагч ба бэлтгэн нийлүүлэгч газарт хийсэн шалгалт зэрэгт тулгуурлан эдгээр үзүүлэлтийг тодорхойлдог. Гэхдээ нийт орлого, зарлагыг бүрэн гүйцэд олж илрүүлэхэд хүндрэлтэй байдаг. Ялангуяа, борлуулалт, худалдан авалт, зардал зэрэг нь бэлэн мөнгөний арилжаанд хамаарагдаж буй тохиолдолд нэлээн төвөгтэй байдаг. Энэ тохиолдолд үйл ажиллагааны үзүүлэлт, цар хүрээ зэргийг (дор vp ашгийн коэффициент гэх) тодорхойлж үүн дээр тулгуурлан ашиг, орлогын хэмжээг тогтоох арга хэрэглэх нь vp дүнтэй байдаг.

Энэ аргыг хэрэглэх тохиолдолд vp ашгийн элемент нь ① тодорхойлох шаардлагатай мөнгөний хэмжээтэй харилцан хамааралтай байх ба пропорциональ холбоонд байдаг, ② татвар төлөгчийн орлого зэргийг тогтооход чухал үзүүлэлт болдог, ③ орлогыг нь үнэн зөв тогтоосон татвар төлөгч болон ④ адил төрлийн ажил үйлчилгээ эрхлэгч татвар

төлөгчөөс ч гэсэн баримт материал цуглуулах боломжтой байх зэрэг нөхцөл шаардлагатай. Иймд тухайн татвар төлөгчийн ажил үйлчилгээний төрөл, хэлбэрт хамгийн тохирох үр ашгийн элементийг сонгох хэрэгтэй ба хяналт шалгалтын явцад тухайн татвар төлөгчийн ажил үйлчилгээний явц, тоног төхөөрөмж зэрэг аж ахуйн үйл ажиллагааны бодит нөхцөл байдлыг тодорхой тогтоох шаардлагатай байдаг.

- 1) Үр ашгийн хувь хэмжээгээр татварын ногдлыг жишгээр тодорхойлох аргын төрөл

Энэхүү арга нь дараах төрөл аргуудаас бүрдэнэ.

- (1) Тvvхий эдийн хэрэглээний хэмжээнд тулгуурлах
- (2) Тvргэн элэгдэх эд хөрөнгийн хэрэглээний хэмжээнд тулгуурлах
- (3) Цахилгаан, ус, тvлшний хэрэглээний хэмжээнд тулгуурлах
- (4) Ажилчдын тоо, тоног төхөөрөмж зэрэг гадаад цар хvрээнд тулгуурлах
- (5) Ажлын өдөрт тулгуурлах

- 2) Үр ашгийн элемент болон үр ашгийн коэффициент

Дараах гол нэр төрлийн ажил үйлчилгээнд хэрэглэхэд оновчтой үр ашгийн элемент болон коэффициентийг авч үзье.

Хүснэгт 2-1

Ажил, үйлчилгээний төрөл	Үр ашгийн үзүүлэлт	Үр ашгийн коэффициент илэрхийлэх арга
Жижиглэнгийн худалдаа	Ажилчдын тоо	Нэг ажилтанд ногдох орлого
	Борлуулалтын талбайн хэмжээ	1м <sup>2</sup> борлуулалтын талбайн хэмжээнд ногдох орлого
	Ажлын өдөр	Ажлын нэг өдөрт ногдох орлого
	Бараа материал	10 мянган төгрөгийн бараа материал тутамд ногдох орлого
Нийтийн хоолны газар	Ажилчдын тоо	Нэг ажилтанд ногдох орлого
	Согтууруулах худалдан авалтын хэмжээ	Согтууруулах ундаа худалдаж авсан нийт үнийн 10 мянган төгрөг тутамд ногдох орлого
	Ширээний тоо	Нэг ширээнд ногдох орлого
	Өрөөний тоо	Нэг өрөөнд ногдох орлого
	Зарцуулсан эрчим хүч, усны хэмжээ	Зарцуулсан эрчим хүч, усны нэгж тутамд ногдох орлого
Бөөний худалдаа	Ажилчдын тоо	Нэг ажилтанд ногдох орлого

	Ажлын өдөр	Ажлын нэг өдөрт ногдох орлого
	Бараа материал	10 мянган төгрөгийн бараа материал тутамд ногдох орлого
	Ачаа тээврийн зардал	Ачаа тээврийн хөлсний 10 мянган төгрөг тутамд ногдох орлого
Боловсруулах вйлдвэрлэл	Ажилчдын тоо	Нэг ажилтанд ногдох орлого
	Зарцуулсан эрчим хвч, усны хэмжээ	Зарцуулсан эрчим хвч, усны нэгж тутамд ногдох орлого
	Техник, тоног төхөөрөмж	Нэг техник, тоног төхөөрөмжөнд ногдох орлого
	Тvvхий эдийн зардал	10 мянган төгрөгийн тvvхий эдийн зардал тутамд ногдох орлого
	Захиалгын зардал	10 мянган төгрөгийн захиалгын зардал тутамд ногдох орлого
Ачаа тээврийн вйлдвэрлэл	Ажилчдын тоо	Нэг ажилтанд ногдох орлого
	Машин, механизмын тоо	Нэг машинд ногдох орлого
Цайны газар	Хэрэглэсэн кофений хэмжээ	1кг кофенд ногдох орлого
Машин засварын газар	Взлэгт орсон машины тоо	Нэг машины взлэгт ногдох орлого
Гоо сайхан, усчин	Зарцуулсан тvvхий эдийн хэмжээ Зарцуулсан эрчим хvчний хэмжээ Ширээний тоо	10 мянган төгрөгний тvvхий эдийн зардал тутамд ногдох орлого Нэг нэгж эрчим хvчний зардал тутамд ногдох орлого Нэг ширээнд ногдох орлого

**Жишээ:**

(адил төрлийн барны вйл ажиллагаа эрхэлдэг татвар төлөгчийн орлого 2100000Тг) ÷ (тухайн адил төрлийн ажил вйлчилгээ эрхлэх татвар төлөгчийн ажилчдын тоо3 ) = тухайн адил төрлийн ажил вйлчилгээ эрхлэх татвар төлөгчийн нэг ажилтанд ногдох дундаж орлого 700,000 Тг × Шалгалтанд хамрагдсан аж ахуйн ажилтны тоо 2 = Орлого 1400 000Тг

- ② Vндсэн материалын зарцуулалтын хэмжээнд тулгуурлан орлогыг тооцоолох

Юуны өмнө худалдаж авсан vндсэн материалын хэмжээг тодорхойлно.



a. [Нийтийн хоол, бүх төрлийн худалдаа болон вйлдвэрлэл эрхлэгч]

(Хяналт шалгалтад хамрагдсан аж ахуйн худалдан авсан үндсэн материалын үнэ)  $\div$  (1 – Адил төстэй аж ахуйн нэгжийн орлогод үндсэн материалын худалдан авалтын үнийн дүнгийн эзлэх хувь) = Орлого

**Жишээ:**

Шалгалтанд хамрагдсан аж ахуйн нэгжийн үндсэн материал худалдан авсан үнийн дүн 30.000.000 Тг  $\div$  (1 – Адил төстэй аж ахуйн нэгжийн орлогод үндсэн материалын үнийн эзлэх хувь 40%) = Орлого 50.000.000Тг

b. [Талх вйлдвэрлэгч]

(Жилд худалдан авдаг шуудай гурлын тоо)  $\times$  (1 шуудай гурилаар вйлдвэрлэх талхны тоо) = Жилд вйлдвэрлэсэн талхны тоо  
(Жилд вйлдвэрлэсэн талхны тоо)  $\times$  (1 ш талхны дундаж үнэ) = Орлого

**Жишээ:**

Жилд худалдаж авсан гурил 30 шуудай  $\times$  (1 шуудай гурилаар хийсэн талхны тоо 100 ш) = Жилд вйлдвэрлэсэн талхны тоо 3000 ш  
Жилд вйлдвэрлэсэн талхны тоо 3000 ш  $\times$  1 ш талхны үнэ 100Тг = Орлого 300000 Тг

c. [Бар эрхлэгч]

(Жилд худалдан авсан пивоны тоо)  $\times$  (Адил төстэй аж ахуй эрхлэгчийн 1 шил пивонд ногдох дундаж орлого) = Орлого

**Жишээ:**

Жилд худалдан авсан пивоны тоо 3000 шил  $\times$  (Адил төстэй аж ахуй эрхлэгчийн 1ш пивонд ногдох дундаж орлого 5000 Тг) = Орлого 15000000Тг

③ Вйл ажиллагааны зардалд тулгуурлан орлогын хэмжээг тооцоолох

a. Зарцуулсан цахилгааны хэмжээнд тулгуурлан орлого тооцоолох

[Жишээ: Хими цэвэрлэгээ]

(Адил төстэй аж ахуйн нэгжийн жилийн орлого  $\div$  зарцуулсан цахилгаан эрчим хүчний хэмжээ)  $\times$  (Шалгалтанд хамрагдсан аж

ахуйн нэгжийн зарцуулсан цахилгаан эрчим хүчний хэмжээ) = Орлого

**Жишээ:**

Адил төстэй аж ахуйн нэгжийн жилийн орлого 25 сая Тг ÷ хэрэглэсэн цахилгаан эрчим хүчний хэмжээ 1000 кв × Шалгалтанд хамрагдсан аж ахуйн нэгжийн хэрэглэсэн цахилгаан эрчим хүч 900 кв = Орлого 22 сая 500 мян.Тг

- b. Зарцуулсан усны хэмжээ (Жишээ: Нийтийн халуун ус, сауна)  
(Адил төстэй аж ахуйн хэрэглэсэн усны нэгж хэмжээнд ногдох дундаж орлого) × (Шалгалтад хамрагдсан аж ахуйн хэрэглэсэн усны хэмжээ) = Орлого

**Жишээ:**

Адил төстэй аж ахуй нэгжийн зарцуулсан 1 литр цэвэр усанд ногдох орлого 300Тг × Шалгалтад хамрагдсан аж ахуйн нэгжийн хэрэглэсэн цэвэр усны хэмжээ 30000 литр = Орлого 9000000 Тг

- c. Зарцуулсан түлш шатахууны хэмжээ (Жишээ: Ачаа тээврийн үйлчилгээ)

• (Шалгалтад хамрагдсан аж ахуйн нэгжийн жилд зарцуулсан бензины өртөг) × (Адил төрлийн аж ахуйн нэгжийн 1 литр бензинд ногдох дундаж тээврийн орлого ÷ адил төстэй аж ахуйн нэгжийн 1 литр бензинд ногдох дундаж өртөг) = Тээврийн орлого

**Жишээ:**

Шалгалтад хамрагдсан аж ахуйн нэгжийн жилд зарцуулсан бензины өртөг 1 сая Тг × Адил төстэй аж ахуйн нэгжийн 1 литр бензинд ногдох тээврийн дундаж орлого 30000Тг ÷ Адил төстэй аж ахуйн нэгжийн 1 литр бензинд ногдох дундаж өртөг 15000 Тг = Тээврийн орлого 2 сая Тг

Тээврийн үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгжийн тухайд зарцуулсан бензинийх нь хэмжээнд үндэслэн доорхи байдлаар орлогыг нь жишгээр тооцож болно.

(Адил төстэй аж ахуйн нэгжийн хэрэглэсэн бензины нэгжид ногдох дундаж орлого) × (шалгалтад хамрагдсан аж ахуйн нэгжийн зарцуулсан бензины хэмжээ) = Орлого

**Жишээ:**

Адил төстэй аж ахуйн нэгжийн 1 литр бензинд ногдох дундаж орлого 30000Тг × Шалгалтад хамрагдсан аж ахуйн нэгжийн зарцуулсан бензиний хэмжээ 70 кл = Орлого 2 сая 100 мянган Тг

- d. Хэрэглэсэн полиэтилен уутны тоо [Жишээ: Хими цэвэрлэгээ, угаалга]

Худалдан авсан X полиэтилен уутны тоо  $\times$  Хэрэглэсэн нэгж X полиэтилен уутанд ногдох орлого + Худалдан авсан Y полиэтилен уутны тоо  $\times$  Хэрэглэсэн нэгж Y полиэтилен уутанд ногдох орлого + Худалдан авсан Z полиэтилен уутны тоо  $\times$  Хэрэглэсэн нэгж Z полиэтилен уутанд ногдох орлого = Орлого

(жич: хими цэвэрлэгээний хөлс тухайн хувцаснаас хамааран харилцан адилгүй байх тул хэмжээ болон чанарын хувьд өөр өөр полиэтилен уут хэрэглэдэг. Эдгээр уутыг төрлөөс нь хамааран X, Y, Z гэж хувааж авч үзсэн болно)

- e. Савладаг уутны тоо [Жишээ: Оймс вйлдвэрлэгч]

Оймс савлахад хэрэглэсэн уутны тоо  $\times$  Оймсны нэгжийн үнэ = Орлого

④ Ажлын өдрөөр тооцоолох

- a. Мэрэг төлөг

Нэг сард үзүүлэхээр ирдэг хүмүүсийн тоо  $\times$  Нэг хүний дундаж төлбөр  $\times$  12 сар = Жилийн орлого

- b. Гутал засвар

Нэг өдрийн орлого  $\times$  Жилд ажилласан хоногийн тоо = Жилийн орлого

- c. Баарны вйлчилгээ

Нэг өдрийн орлого (Бодит тоо)  $\times$  Жилд ажилласан хоногийн тоо = Жилийн орлого

- d. Хүнсний жижиглэнгийн худалдаа

Тодорхой хугацааны борлуулалтын орлого  $\div$  тухайн хугацааны борлуулалтыг тооцсон цагийн тоо)  $\times$  нэг өдрийн борлуулалтыг тооцсон цагийн тоо  $\times$  жилд ажилласан хоногийн тоо = Жилийн орлого

(Жич: ажилласан хоногоор тооцохдоо нэг өдөр эсвэл нэг сард ногдох хүний тоо, мөнгөний дүн нь жилийн дундажтай тохирч байгаа тохиолдолд оновчтой болох бөгөөд их зөрүүтэй байх

тохиолдолд тооцоо алдаатай гарах учраас өөр тооцоолох арга байхгүй нөхцөлд л энэ аргыг хэрэглэнэ.)

[2] Адил төстэй аж ахуйн нэгжийн жишгээр тооцоолох арга

Энэ арга нь шалгалтад хамрагдсан аж ахуй эрхлэгчийн борлуулалтын хэмжээ (орлого), борлуулалтын өртөг (худалдан авалтын хэмжээ), вйл ажиллагааны зардлын аль нэг нь мэдэгдэж байх эсвэл борлуулалтын өртөг дотроос зардлын үндсэн элементийн зарцуулалтын хэмжээг мэдэж байх тохиолдолд эдгээр үзүүлэлтэнд үндэслэн адил төстэй аж ахуйн нэгжийн борлуулалт, зардал, ашигтай харьцуулан орлогын хэмжээг тооцоолон гаргах арга юм.

Доор баарны вйлчилгээ явуулдаг аж ахуйн жишээн дээр жишгээр тооцох аргыг тайлбарлая.

**Жишээ:**

Шалгаж буй Х аж ахуй нь хөл хөдөлгөөн ихтэй газар баар ажиллуулдаг. Шалгалтаар очиход орлого, зардлын тооцоо хөтөлсөн ямар нэгэн баримт бүртгэлгүй байлаа. Уг этгээдээс өөрөөс нь асууж танилцах, шөнийн ажлын үеэр газар дээр нь байдалтай танилцах зэргээр жилийн турш тэнд өөрөөс нь гадна 3 хvн ажилладаг болохыг тогтоов. Мөн пиво, вино, архи зэрэг согтууруулах ундааг ойролцоох Ү дэлгүүрээс авдаг болох нь тогтоогдсон тул уг нийлүүлэгчийг шалгах явцад Х-д борлуулсан барааны бүртгэл байсан бөгөөд Х-ийн Ү-ээс авсан барааны үнэ 2 сая 100 мянган Тg болохыг тогтоов. Зуушыг Х-д авчирч өгдөг газрын хаягийг тогтоож чадаагүй учир орлогыг үнэн зөв тогтоох боломжгүй байлаа.

Хяналт шалгалтын байцаагч адил төстэй аж ахуйн нэгж байгууллагатай харьцуулсны үндсэн дээр орлогын хэмжээг тодорхойлохын тулд уг татварын албанд харьяалагддаг Х-тэй вйл ажиллагааны цар хэмжээ, ажилчдын тоо, байрлал зэргээрээ төстэй А, В, С гэсэн 3 аж ахуйг сонгож авав.

Эдгээрийн дотроос А-ийн татварын тайланд дурьдсан мөнгөний хэмжээг шалгалтаар засаж залруулсан байсан бөгөөд В, С-ийн татварын тайлангийн дvнгийн хэмжээ А-аас бага байсан боловч үндэслэлгүй гэж үзэх шалтгаан байгаагүй учир эдгээрийн жишгийг авч хэрэглэхээр болов.

Адил төстэй аж ахуйн орлогын төрөл болон борлуулалтын өртөг зэргийг 2-2 хvснэгтээр харуулав.

Хүснэгт 2-2

(Нэгж: Мян. төг)

Ангилал		Адил төстэй а.а		
		А	В	С
① Борлуулалтын хэмжээ		18000	1600 0	10000
② Б/ Өртөг	③ Согтууруулах ундаа худалдан авалтын хэмжээ	2700	2300	1800
	Согтууруулах ундааны худалдан авалтын орлогод эзлэх хувь ③ ÷ ①	0.15	0.14	0.18
	④ Зууш	600	400	300
	⑤ Дvн ③ + ④	3300	2700	2100
	Борлуулатын өртөгийн орлогод эзлэх хувь ⑤ ÷ ①	0.18	0.17	0.21
⑥ Нийт ашиг (①-⑤)		14700	1330 0	7900
Нийт ашгийн түвшин (⑥ ÷ ①)		0.82	0.83	0.79
⑦ з а р д а л	⑧ Боловсон хүчний зардал	5500	4600	3500
	Боловсон хүчний зардлын борлуулалтын орлогод эзлэх хувь (⑧ ÷ ①)	0.31	0.29	0.35
	⑨ Бусад зардал	900	700	500
	⑩ Дvн (⑧+⑨)	6400	5300	4000
	Вйл ажиллагааны зардлын борлуулалтын орлогод эзлэх хувь (⑩ ÷ ①)	0.36	0.33	0.40
⑪ Вйл ажиллагааны ашиг (⑥-⑩)		8300	8000	3900
Вйл ажиллагааны ашгийн орлогод эзлэх хувь (⑪ ÷ ①)		0.46	0.50	0.39

Тэмдэглэл	Ажиллагсдын тоо	4 хүн	3 хүн	3 хүн
-----------	-----------------	-------	-------	-------

Согтууруулах ундааны худалдан авалтын орлогод эзлэх дундаж хувь хэмжээ (Адил төстэй аж ахуйн нэгжүүдийн дундаж хувь) = { (A) 0.15 + (B) 0.14 + (C) 0.18} ÷ 3 = 0.16

Цалин хөлсний зардлын дундаж хувь (Адил төстэй аж ахуйн нэгжүүдийн дундаж хувь) = { (A) 0.31 + (B) 0.29 + (C) 0.35} ÷ 3 = 0.32

Вйл ажиллагааны ашгийн борлуулалтын орлогод эзлэх дундаж хувь (Адил төстэй аж ахуйн нэгжүүдийн дундаж хувь) = { (A) 0.46 + (B) 0.50 + (C) 0.39} ÷ 3 = 0.45

Согтууруулах ундааны худалдан авалтын өртгийн борлуулалтын орлогод эзлэх хувь хэмжээнд тулгуурлан тооцъё.

- (Шалгагдаж буй X аж ахуйн согтууруулах ундаа худалдан авалтын хэмжээ 2 сая 100 мянганТг) ÷ (Адил төстэй аж ахуйн согтууруулах ундааны орлогын дүнд эзлэх хувь хэмжээ) 0.16 = (X-ийн борлуулалтын орлого) 13 сая 125 мянТг
- (X-ийн борлуулалтын орлого) 13 сая 125 мянТг × (Адил төстэй аж ахуйн вйл ажиллагааны ашгийн борлуулалтын орлогод эзлэх дундаж хувь) 0.45 = (X-ийн вйл ажиллагааны ашиг) 5 сая 906 мянТг

Согтууруулах ундаа худалдан авсан мөнгөний хэмжээ мэдэгдэхгүй, цалин хөлсны зардал 4 сая 300 мян.Тг гэдгийг тогтоосон нөхцөлд

- (X аж ахуйн цалин хөлсны зардал) 4 сая 300 мян Тг ÷ (Адил төстэй аж ахуйн цалин хөлсний борлуулалтын орлогод эзлэх дундаж хувь) 0.32 = (X-ийн борлуулалтын орлого) 13 сая 437 мянТг
- (X-ийн борлуулалтын орлого) 13 сая 437 мянТг × (Адил төстэй аж ахуйн орлогод эзлэх вйл ажиллагааны ашгийн дундаж хувь) 0.45 = (X-ийн вйл ажиллагааны ашиг) 6 сая 46 мянТг

Жич: Согтууруулах ундаа худалдан авалтын хэмжээ болон цалин хөлсний хэмжээнд үндэслэн тооцоолох аргыг эдгээр үзүүлэлт нь борлуулалтын орлоготой харилцан хамааралтай бөгөөд мөнгөний хэмжээ харьцангуй их байх нөхцөлд хэрэглэнэ)

### [3] Хөрөнгө, өр төлбөрийн өөрчлөлтөөр орлого тодорхойлох

Орлогын хэмжээг хөрөнгө, өр төлбөрийн өөрчлөлтөөр тооцоолох арга нь урьд дурьдсанчлан орлого зарлага дээр үндэслэн ашиг алдагдлыг тооцоолох аргаас өөр[ (Хугацааны эцэс дэхь хөрөнгө - Хугацааны эхэн дэхь хөрөнгө) - (Хугацааны эцэс дэхь өр төлбөр- Хугацааны эхэн дэхь

өр төлбөр) + Хувийн хэрэглээний зардал (Амьжиргааны зардал) - (Үйл ажиллагааны бус орлого) = Үйл ажиллагааны ашиг] гэсэн тэнцэлд тусгагдсан цэвэр хөрөнгийн өсөлт бууралтаар орлого шууд тооцоолох арга юм. Иймээс энэ аргаар тооцоо хийхийн тулд хөрөнгө, өр төлбөрийн хэмжээг үнэн зөв тогтоох хэрэгтэй. Доор энэ аргаар тооцоо бодох дарааллыг авч үзье.

1) Цэвэр хөрөнгийн хэмжээ

Тухайн жилийн хугацааны эхэн, эцсийн байдлаарх хөрөнгө, өр төлбөрийн үлдэгдлийн хэмжээг тогтооно. Ингэхдээ хөрөнгө өссөн тохиолдолд хадгаламж багассан, өр төлбөр нэмэгдсэн эсэхийг шалгах хэрэгтэй. Мөн өр төлбөр өссөн байвал хөрөнгө нэмэгдэж үү үгүй юу гэдгийг шалгах хэрэгтэй.

① Түгээмэл арга

- a. Татвар төлөгч уг хvний тайлан, ярилцлага зэргээс хөрөнгө, өр төлбөрийн хэмжээг үнэн зөвөөр тодорхойлно.
- b. Жил бүр онцын өөрчлөлт байдаггүй балансын зүйл жишээлбэл бэлэн мөнгө, бараа материал зэргийг хугацааны эхэн, хугацааны эцэс дэхь хэмжээгээр авч үзэж болно.

② Хадгаламж

Хадгаламжийн хувьд санхүүгийн байгууллагаас мэдээлэл авч тогтооно. Энэ тохиолдолд гэр бүлийнхнийхээ нэр дээр бичсэн хадгаламжийг ч гэсэн илрүүлж орлогын тооцоонд оруулах ба гэр бүлийн нэр дээрх хадгаламж нь тухайн гэр бүл өөр эх үүсвэрээс олсон орлого, тухайлбал, цалингийн орлого орж ирсэн эсэхийг шалгаж орж ирсэн тохиолдолд аж ахуйн үйл ажиллагааны орлогоос хасч тооцно.

Мөн хадгаламжийн мөнгө багассан тохиолдолд уг мөнгөөр эд хөрөнгө худалдаж авсан эсэхийг тогтооно.

③ Дансаарх авлага, хүлээгдэж байгаа авлага

Дансаарх авлагыг харилцагч байгууллагад нь хийх шалгалтаар илрүүлж болно.

④ Барилга байгууламж болон түүний дагалдах тоног төхөөрөмж

Барилгын ажлын зардал, худалдан авалтын зардал зэрэг тухайн барилга байгууламжийг худалдаж авсан үнийг тогтооно. Элэгдэл хорогдлын тооцоог өр төлбөрийн хэсэгт бичигдсэн хуримтлагдсан элэгдлийн зардлаар тооцно.

⑤ Авто машин тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж сэлбэг хэрэгсэл

Худалдан авалтын зардлаас үнийг тогтоож элэгдэлийг өр төлбөрийн хэсэг дэхь хуримтлагдсан элэгдлийн хэмжээгээр тогтооно.

- ⑥ Дансаарх өглөг, төлөгдөөгвй байгаа зардал  
Дансаарх авлагыг харилцагч байгууллагад нь хийх шалгалтаар илрүүлнэ.

- ⑦ Зээл

Зээлийг санхүүгийн байгууллагад хийх шалгалтаар олж тогтооно. Энэ тохиолдолд аж ахуйн зориулалтаар авсан эсэх, эсвэл хувьдаа буюу гэр ахуйн зориулалтаар зээл авсан эсэхийг тогтооно. Мөн зээлийн хэмжээ нэмэгдсэн тохиолдолд өөр эд хөрөнгө худалдаж авсан эсэхийг анхаарна.

- ⑧ Хуримтлагдсан элэгдэл, хорогдлын зардал

Хуримтлагдсан элэгдэл, хорогдлын зардлыг өмнөх оны эцэс дэхь хуримтлагдсан зардалд тухайн оны элэгдэл, хорогдлын зардлыг нэмж тооцно.

- ⑨ Цэвэр хөрөнгийн хорогдол болон өсөлт

Хөрөнгийн өсч буурсан хэмжээнээс нэмэгдэж буурсан өр төлбөрийн хэмжээг хассан цэвэр хөрөнгийн хэмжээг өмнөх оны эцэс дэхь дүнгээс тухайн оны сүүлийн дүнг хасч тогтооно.

- 2) Хувийн хэрэглээний зардлын (амжиргааны зардал гэх мэт) өсөлтийг тогтоох

Хувийн хэрэглээний зардал (амьжиргааны зардал) нь аж ахуйн үйл ажиллагааны орлогоос гарах тохиолдол олон байдаг тул аж ахуйн орлогыг тооцсоны үндсэн дээр цэвэр хөрөнгийн хэмжээнд нэмж тооцно. Хэрэглээний зардалд дараах зардал орно.

- ① Амьжиргааны зардал

Амьжиргааны зардлыг тооцохдоо бус нутаг болон өрхийн гишүүдийн тоогоор гаргасан стандарт хэмжээ буюу статистикийн бичиг баримтыг ашиглана. Ийм баримт бүтгэл байхгүй тохиолдолд хяналт шалгалтанд хамрагдах татвар төлөгч хувь хүн болон түүний гэр бүлээс асууж лавлах замаар хоол хүнсний зардал, хувцас хунар худалдан авсан зардал, гэр ахуйн эд хогшил худалдан авсан зардал, сургуулийн төлбөр, унааны зардал, байрны хөлс, баяр ёслол, хурим найр зэрэг зарлуудын нийлбэрээр жилийн амьжиргааны зардлын дүнг тодорхойлно.



② Амьжиргааны зардлаас бусад зардлын өссөн хэмжээ

Амьжиргааны зардлаас бусад звйлд гарсан зардал буюу үйл ажиллагааны бус зардалд дор дурдсан зардал орно.

1. Орлогын татвар, орон нутгийн албан татвар гэх мэт
2. Гэр ахуйн зориулалтаар авсан зээлд төлсөн мөнгө
3. Сургалтын төлбөр, хурим, аялал зэрэг түр хугацаанд гарсан их хэмжээний зардал

③ Вйл ажиллагааны бус орлогын өсөлт бууралтыг тогтоох

Вйл ажиллагааны бус орлого нь бизнесийн үндсэн орлогод тооцогдохгвй тул цэвэр хөрөнгийн хэмжээнээс хасна. Вйл ажиллагааны бус орлогод дараах орлогыг хамааруулна.

1. Хадгаламжийн хvv
2. Хувьцааны ногдол ашиг

Хүснэгт 2-3

Хөрөнгө, өр төлбөрийн өсөлт бууралтаар үйл ажиллагааны ашгийг тооцох нь

III Хэсэг-2 Татварын ногдлыг жишгээр тодорхойлох арга

(нэгж: 1000Тг)

Балансын зүйл			Улирлын эхний дүн (1 сарын 1)	Улирлын сүүлийн дүн (12 сарын 31)	(② - ①)
Хөрөнгө	Бэлэн мөнгө	a	200	200	0
	Хадгаламж	b	6,300	7,100	800
	Дансаарх авлага	c	1,000	1,000	0
	Бараа материал	d	3,000	3,000	0
	Барилга байгууламж	e	6,000	6,000	0
	Машин, тээврийн хэрэгсэл	f	1,200	1,200	0
	Нийт	g	17,700	18,500	0
Өр төлбөр	Дансаарх өглөг	h	420	650	230
	Зээл	i	5,100	4,700	400
	Хуримтлагдсан элэгдэл, хорогдол	j	2,518	2,761	243
	Нийт	k	8,038	8,111	73
	Цэвэр хөрөнгийн хэмжээ (g-k)	l	9662	10389	727
Нэмж тооцох vзvvлэлт ????????? ?	Амжиргааны зардал	m			4,412
	Орлогын татвар	n			89
	Орон нутгийн А.Т	o			118
		p			
		q			
	Нийт	r			4,619
хасч тооцох vзvvлэлт	Хадгаламжийн хvv	s			121
	Ногдол ашгийн орлого	t			0
	Нийт	u			121
Вйл ажиллагааны ашиг (l+r-u)			v		5,225

Хүснэгт 2-4

Элэгдэл, хорогдлын зардлыг тооцох нь

(нэгж: 1000Tg)

Ангилал	Худалдаж авсан үнэ	Ашиглалтын хугацаа	Элэгдэл хорогдлын зардлын хэмжээ		
	Элэгдэл тооцох үнийн дүн	Элэгдлийн хувь хэмжээ	Өмнөх жилийн эцэс дэх хуримтлагдсан элэгдэл (①)	Өмнөх оны жилийн дундаж дэх элэгдэл хорогдлын зардал (②)	Хуримтлагдсан элэгдлийн хэмжээ (①+②)
Барилга байгууламж	6000	40 жил	2,160	135	2,295
	5400	0.025			
Авто машин	1200	10 жил	358	108	466
	1080	0.100			
Нийт дүн			2,518	243	2,761

Жич:

1. Хөрөнгө, өр төлбөрийн хэсэгт дээр дурдсан зүйлээс гадна нэмж бичих өөр зүйл байвал оруулах
2. Хөрөнгө, өр төлбөрийн нэмэгдэж буурсан хэмжээнд тулгуурлан жишиг тооцоо хийсний дүнд тодорхойлсон үйл ажиллагааны ашиг нь бодитой биш байвал, мөн жил тутамын үйлдвэрлэлийн хэмжээнд өөрчлөлт ороогүй нь тогтоогдвол шалгалтыг бүрэн гүйцэд бус гэж үзэн дахин шалгах хэрэгтэй. Гэхдээ энэ аргаар тодорхойлоход хүндрэлтэй тохиолдолд өөр хувилбар аргыг ашиглан тооцоо хийж болно.

### **Бүлэг 3**

### **3. Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын хяналт шалгалт**

Монгол улсын ААНБ-ын орлогын албан татварын хууль нь бусад ихэнх оронд хэрэглэгддэг татвараа өөрөө тодорхойлж төлөх системийн үндсэн дээр хэрэгждэг бөгөөд татвар төлөгч өөрөө татвар ногдуулах орлогоо тооцоолж тайлан гаргадаг. Татварын тайлангийн тооцоолол үнэн зөв эсэх, мөн татварын хууль тогтоомжинд нийцэж буй эсэхийг татварын хяналт шалгалтаар тогтоодог.

Татварын хяналт шалгалт хийхгвйгээр татварын ачаалал тэгш шударга байгаа гэж найдахад бэрх бөгөөд нэг талаас иргэдийн өмчийн эрх алдагдаж болох ба нөгөө талаас улсын төсвийн болон нийгмийн хэрэгцээ шаардлагыг хангаж чадахгвйд хүрнэ.

Иймд татварын хяналт шалгалт нь татвар өөрөө тодорхойлох системд татварыг үнэн зөв ногдуулахад чухал үүрэг гвйцэтгэдэг.

#### **3.1 ААНБОАТ-ын хяналт шалгалтанд тулгарч буй бэрхшээлтэй асуудлууд**

Монгол улсад татвар төлөгчийн тодорхойлсон ААНБОАТ-ын тайланг шалгах систем үр дүн муутай байна гэсэн асуудал яригддаг. Тухайлбал, хяналт шалгалтанд хамрагдах татвар төлөгчийг сонгох арга, хяналт шалгалтын арга барил, татварын нотлох баримт, мэдээллийг олж авч ашиглаж буй байдлыг дурдаж болох юм. Энэ бүлэгт эдгээр асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар санал зөвлөмж гаргав.

#### **3.2 ААНБОАТ-ын хяналт шалгалтын системийг боловсронгуй болгох арга зам**

##### **3.2.1. Хяналт шалгалтанд хамрагдах татвар төлөгчийг сонгох аргыг боловсронгуй болгох нь**

[1] Хяналт шалгалтанд хамрагдах татвар төлөгчийг сонгохдоо юуны өмнө

- ① хууль бус арилжаа явуулдаг тухай мэдээлэл бүхий татвар төлөгч
- ② вйл ажиллагааны цар хүрээ нь мэдэгдэхвйц өсч буй татвар төлөгч
- ③ хяналт шалгалтанд хамрагдах татвар төлөгчтэй харилцагч байгууллага
- ④ онцгой төрлийн ажил вйлчилгээ эрхэлдэг татвар төлөгч
- ⑤ шалгах графикт хугацаа нь болсон аж ахуйн нэгж ([2]2) болон жил бүр хяналт шалгалт хийх шаардлагатай аж ахуйн нэгжийг ([2]3) нэн тэргүүнд сонгоно.

Түүнчлэн санхүүгийн тайлан зэрэг татварын албанд ирүүлсэн бусад бичиг баримтанд үндэслэн судалгаа хийж, санхүүгийн харьцаануудыг тооцон дүн шинжилгээ (менежментийн дүн шинжилгээ) хийх замаар хэвийн бус тооцоо, зөрчил олж илрүүлэн хяналт шалгалтанд хамрагдах татвар төлөгчийг сонгож болно.

Үүний тулд татвар төлөлтийн хувийн хэргээс ААНБ-ын өнгөрсөн хугацааны татварын тайлан, өмнөх хяналт шалгалтын үр дүнгийн талаар судалж мэдсэний үндсэн дээр гаргасан зөрчлийн байдлаар нь ААНБ-ыг таван зэрэглэлд («өмнөх хяналт шалгалтуудын үр дүнд тулгуурлан ангилал тогтоох» гэх) борлуулалтын орлогоос нь хамааран хэд хэдэн ангилалд (дор «борлуулалтын хэмжээгээр ангилал тогтоох» гэх) ангилсаны үндсэн дээр шалгалтанд хамруулах аж ахуйн нэгжийг сонгох болно.

Өөрөөр хэлбэл, хяналт шалгалтын үр дүнг дээшлүүлэхийн тулд татвар төлөгчийг сонгохдоо «өмнөх хяналт шалгалтуудын үр дүнд тулгуурлан ангилах арга» болон «борлуулалтын хэмжээгээр ангилах арга»-г хослуулан хэрэглэх нь зүйтэй. Түүнчлэн эдийн засгийн нөхцөл байдалд нь дүн шинжилгээ өгөх замаар үр ашигтай ажиллаж байгаа аж ахуйн нэгжийг сонгож ерөнхийд нь тодорхойлсоны үндсэн дээр («онцгой хяналт шалгалтанд хамрагдах аж ахуйн нэгжийн төрлийг сонгох арга» гэх) сонгож болно.

Энэ аргыг улам үр дүнтэй болгохын тулд мэдээлэлийн сайн тогтолцоог (3.2.6) бүрдүүлэх хэрэгтэй байдаг.

- [2] Хяналт шалгалтын объектийг сонгоход «өмнөх хяналт шалгалтуудын үр дүнд тулгуурлан ангилах арга» -г хэрэглэх тухай

Энэ нь өнгөрсөн онуудын тайлан гаргалт, татвар төлөлт, хяналт шалгалтын үр дүн зэрэгт тулгуурлан бүх ААНБ-ийг А (шалгалт хийх шаардлагагүй), В (3-5 жил тутам шалгалт хийх), С (байнга холбоотой байх) гэсэн гурван хэсэгт хуваан хяналт шалгалтын бэлтгэл шатанд эргэлзээтэй бөгөөд дээд ангилалд багтах ААНБ-д голлон шалгалт хийх арга юм.

*(1) А зэрэглэлийн ААНБ (шалгалт хийх шаардлагагүй)*

Шалгалт хийх шаардлагагүй аж ахуйн нэгж гэдэг нь ① урьд өмнөх онуудын үйл ажиллагааны болон татварын тайлан тодорхой бөгөөд үнэн зөв, ② өнгөрсөн онуудад татварын зөрчил маргаантай асуудал гарч байгаагүй, ③ татвараа хугацаанд нь төлдөг, тайлангаа хугацаанд нь тушаадаг, ④ аж ахуйн нэгжийн удирдлага болон тухайн аж ахуйн нэгжийн талаар ямар нэгэн муу яриа гарч байгаагүй бөгөөд татвараа идэвхтэй төлдөг, ⑤ борлуулалтын хэмжээ бага жижиг хэмжээний аж ахуй нэгж, ⑥ сул зогссон, татан буугдсан буюу цаашид тооцоо хийхгүй ААНБ-ыг хэлнэ.

Тухайн ААНБ-ыг энэ ангилалд хамруулсан нөхцөлд 5 жилийн хугацаанд хяналт шалгалтанд хамруулахгүй бөгөөд уг хугацаа дууссаны дараа дахин зэрэглэл тогтооно.

*(2) В зэрэглэлийн ААНБ ( ердийн графикаар шалгалт хийх)*

Ердийн график шалгалтанд хамрагдах ААНБ гэдэг нь ① энгийн алдаа гаргах буюу тайланд нь засвар байнга хийгддэг ② тайланд тусгасан орлого нь нийтийн жишигтэй ойролцоо боловч бага зэрэг эргэлзээтэй ③ удирдлага болон компанийн талаар ямар нэгэн цуу яриа гараагүй ч огт шалгалт хийхгүй үлдээж боломгүй аж ахуйн нэгжийг хэлнэ. Тухайн ААНБ-д 3-5 жил тутам хяналт шалгалт хийнэ. Гэхдээ шалгалтын бэлтгэл шатанд эргэлзээтэй тодохой бус тооцоо, баримт илрүүлсэн тохиолдолд эсвэл зөрчил гаргасан тухай мэдээлэл болон баримт бичиг олж авсан тохиолдолд хяналт шалгалт хийнэ.

*(3) С зэрэглэлийн ААНБ (байнга шалгалтанд хамруулах шаардлагатай)*

Байнга шалгалтанд хамруулах шаардлагатай ААНБ гэдэг нь ① өнгөрсөн онуудын хяналт шалгалтаар байнга их хэмжээний зөрчил илэрч байсан ② зөрчилтэй тооцоо болон тайлан гаргах эрсдэл өндөр ③ удирдлага болон компанийн талаар таагүй хэл ам гардаг ④ зөрчил гаргаж буй талаар байнга мэдээлэл, баримт ирдэг ААНБ-ийг хэлнэ. Тухайн ААНБ-ыг зарчмын хувьд жил болгон ямар нэгэн асуудалгүй гэж таамаглаж болох тохиолдолд ч гэсэн нарийн хяналт шалгалт хийх зэргээр үргэлж хяналтанд байлгана.

[3] Хяналт шалгалтанд «борлуулалтын хэмжээгээр нь ангилах арга»-г хэрэглэх тухай

Борлуулалтын орлогоос хамааран ААНБ-ийг таван зэрэглэлд хувааж 1-2 зэрэглэлийг бага шатлалтай, 3-4 зэрэглэлийг дунд шатлалтай, 5 зэрэглэлийг өндөр шатлалтай ААНБ гэж гурван зэрэглэлд хувааж өндөр шатлалтай ААНБ-ийг хяналт шалгалтанд түлхүү хамруулж бага шатлалтай ААНБ-д хялбарчилсан шалгалт хийнэ.

Дунд шатлалд хамаарах ААНБ-д ердийн графикт хугацаанд шалгалт хийнэ. Гэхдээ татвараас зайлсхийх болон татвар ногдох орлогоо бууруулсан хэрэгт сэжиглэгдэж байгаа буюу ийм зөрчил гаргасан нь нотлогдсон тохиолдолд дунд, бага шатлалд хамаарах ААНБ-ийг ч гэсэн хяналт шалгалтанд хамруулна. Энэ нь цөөн тооны хяналт шалгалтын байцаагчийг үр дүнтэй ашиглахад тустай.

[4] «Онцгой ажил үйлчилгээний төрлөөр нь хяналт шалгалтын объектийг сонгох арга»-г хэрэглэх тухай

Энэ арга нь хязгаарлагдмал тооны татварын хяналт шалгалтын байцаагчийн ажлыг үр дүнтэй хуваарилах арга бөгөөд бүх татвар

төлөгчдийг хамруулах боломжгүй өнөөгийн нөхцөлд зөвхөн том аж ахуйн нэгж болон зөрчил их гаргадаг татвар төлөгч, өмнөх онуудын татварын тайлан болон хяналт шалгалтын үр дүнгээс үл хамааран их ашигтай гэж үзэж болох ажил үйлчилгээний төрөлд голлон шалгалт хийх арга юм.

Дээр дурдсан аж ахуйн нэгжийг тодорхойлохдоо тухайн цаг хугацаан дахь үйл ажиллагааны ашиг өндөр аж ахуйг сонгох ба нийт улс орныг хамрах тохиолдолд татварын албаны төв байгууллага шийдвэр гарана. Улмаар доод шатны татварын албад уг шийдвэрийн дагуу тус тусын харъяа нутаг дэвсгэрийн онцлогт уялдуулан бусад ажил үйлчилгээний төрлийг нэмж тодорхойлон эдгээр аж ахуйн нэгжүүдэд нэн тэргүүнд хяналт шалгалт хийнэ.

### **3.2.2 Бэлтгэл шалгалтыг боловсронгуй болгох нь**

Хяналт шалгалтын объектоор сонгогдсон татвар төлөгчийг шалгахдаа юуны өмнө урьдчилан уг татвар төлөгчтэй холбоотой баримт мэдээлэлийг цуглуулж шалгах, (дор, баримт мэдээллийн систем-д өгүүлнэ) тухайн татвар төлөгчийн эрхэлж буй ажил үйлчилгээний төрөл, онцлог зэрэг хяналт шалгалтын явцад анхаарал хандуулах шаардлагатай зүйлсийг тогтоох шаардлагатай байдаг.

#### **[1] Татвар төлөлтийн хүснэгтийг судлах**

Татвар төлөлтийн хүснэгт гэдэг нь татвар төлөгчийн төлж ирсэн татварын төрөл, татварын дүн, татвар төлөлтийн биелэлтийг тэмдэглэсэн жагсаалт бөгөөд өмнөх онууд дахь тухайн татвар төлөгчийн санхүүгийн үзүүлэлтүүдийг харуулсан байдаг тул жил тутмын харьцуулалт хийж боломжтой байдаг. Мөн урьд онууд дахь хяналт шалгалтын тухай тэмдэглэл хийсэн байдаг.

Хяналт шалгалтанд хамрагдах татвар төлөгчийн татварын тайлан, татвар төлөлтийн хүснэгтийг хяналт шалгалтын хэлтсийн хариуцах байцаагч бүрдүүлэх бөгөөд эргэлзээтэй буюу тодорхой бус тооцоо, зөрчил байгаа эсэхийг судалж засварлах бөгөөд хяналт шалгалтын объектоор сонгох шаардлага байгаа эсэхийг тогтооно. Шалгалтын бэлтгэл ажлын эцэст аж ахуйн нэгжүүдийг «ажлын байран дахь хяналт шалгалт» эсвэл «хялбарчилсан шалгалт»-нд хамруулахаар хуваарилна. Энэ нь нийт татвар төлөгчдийг шалгалтанд хамруулах боломжгүйгээс гадна тэгэх шаардлага ч байхгүйтэй холбоотой.

Энэ мэтчилэн бэлтгэл шалгалтын үр дүнд ажлын байран дахь хяналт шалгалт болон хялбарчилсан хяналт шалгалтын объектыг тогтоож татвар төлөлтийн хүснэгтэнд тэмдэглэсний дараа шалгалтын төлөвлөгөөг боловсруулна.

#### **[2] Баримт мэдээллийг судлах**



Татварын тайлангийн зохистой твшинг хангах зорилгоор чанартай хяналт шалгалт хийхийн тулд татвар төлөгчийн вйл ажиллагаа, эд хөрөнгөнд хамаарах бичиг баримт, мэдээллийг цуглуулах шаардлага гардаг. Энэ талаар 3.2.6-д тодорхой өгүүлэх болно.

ААНБ-д хяналт шалгалт хийх явцад татварын тайлангаа үнэн зөв гаргаагүй байж болох татвар төлөгчтэй хийсэн аж ахуйн вйл ажиллагааг баримтжуулах зэрэг боломжийг ашиглан шаардлагатай баримт мэдээллийг цуглуулах хэрэгтэй бөгөөд мөн сонин хэвлэл, зурагт, радио зэрэг олон нийтийн мэдээлэлийн хэрэгслээр нэвтрүүлэх аж ахуйн нэгжийн зар сурталчилгааг цуглуулах нь зүйтэй.

### 3.2.3 Шалгалтанд хамрагдах ААНБ-ыг эцэслэн тогтоох

Урьд өмнөх хяналт шалгалтуудын үр дүнд тулгуурлан ангилах арга, борлуулалтын хэмжээгээр ангилах арга, онцгой ажил үйлчилгээний төрлөөр хяналт шалгалтанд хамруулах аргад тулгуурлан нарийн сонголт хийгдсэн татварын тайланд урьдчилсан шалгалт хийж татварын тайлан, бэлтгэл шалгалтын тайлан, татвар төлөлтийн хүснэгтийг тухайн хариуцсан хяналт шалгалтын байцаагч бүрдүүлж дор дурдсан үзүүлэлтийн дагуу хяналт шалгалтанд хамруулах шаардлагатай эсэх талаар эцсийн дүгнэлт гаргаж сонголт хийнэ.

«Нэгдүгээр шатны сонголт хийх үзүүлэлт»

- ① Зөрчлийн тухай мэдээлэл
- ② Бусад татвар төлөгчийг шалгалтын явцад олж авсан мэдээллээр зөрчил гаргасныг илрүүлсэн
- ③ Татварын тайлан гаргаагүй
- ④ Зохиомол хуурамч тооцоо гаргасан нь тогтоогдсон
- ⑤ Үйлдвэр, салбар нэгж шинээр нэмж байгуулах зэргээр ажил үйлчилгээний цар хүрээ нь мэдэгдэхүйц өссөн
- ⑥ Тухайн тайлант хугацаанд эргэлзээ төрүүлэхүйц тооцоо илэрсэн бөгөөд учир шалтгаан нь тодорхой бус

«Хоёрдугаар шатны сонголт хийх үзүүлэлт»

- ① Бусад ААНБ-тай харьцуулахад орлого бага, зардал их
- ② Ижил төрлийн ААНБ-тай харьцуулахад урьд онуудын борлуулалтын ашгийн твшин мэдэгдэхүйц бага
- ③ Борлуулалтын орлого, ашиг өөрчлөгдөөгүй бөгөөд эдийн засгийн аливаа нөлөө тусаагүй байх
- ④ Нэлээн хугацааны туршид (3-5 жил) татварын шалгалт хялбарчилсан аргаар хийгдэж, бүрэн хэмжээний шалгалт хийгдсэнээс хойш нэлээд хугацаа өнгөрсөн
- ⑤ Өмнөх хяналт шалгалтуудаар ноцтой зөрчил, нуугдмал орлого илэрч байсан бөгөөд татвар төлөлтийн явц муу

- ⑥ Байгуулагдсанаас хойш анхны улирал өнгөрч байгаа
- ⑦ Онцгой ажил үйлчилгээ эрхэлдэг гэх мэт

Нэгдүгээр шатны сонголтоор нэн тэргүүнд зайлшгүй хяналт шалгалтанд хамрагдах ААНБ-ийг тогтоох ба хоёрдугаар шатны сонголтыг үүний дараа хийнэ.

### 3.2.4 Татвар төлөлтийн хүснэгтийг боловсронгуй болгох

Татвар төлөлтийн хүснэгт гэдэг нь татвар төлөлтийн явцыг харуулсан баримт бөгөөд татварын бүртгэл гэж хэлж болно. Энэ хүснэгтийг шалгалтын объект сонгох, шалгалт хийх явцад ашиглахын тулд энгийн ойлгомжтой бөгөөд нэгэн загварт оруулж боловсруулдаг.

- (1) Хяналт шалгалтаар үгүйсгэгдсэн баримт, тайлан зэргийг татвар төлөлтийн хүснэгтэнд тэмдэглэж тухайн ААНБ-д хамаарах баримт мэдээлэлийг нэмж оруулна.
- (2) Татвар төлөлтийн хүснэгтийг голчлон хяналт шалгалтын сонголт хийх болон шалгалтын бэлтгэл ажлын явцад хэрэглэх ба мөн ажлын байран дахь хяналт шалгалтын вед болон шалгалт дууссаны дараа хэрэглэдэг. Өөрөөр хэлбэл, шалгалтын объектыг сонгох бэлтгэл ажлын явцад буюу шалгалтын үзүүлэлтийг тогтооход үндсэн баримт болгон ашигладаг. Мөн мэдээлэлийн бааз боловсруулахад хэрэглэнэ.
- (3) Татвар төлөлтийн хүснэгтэнд бичих үзүүлэлтийг боловсронгуй болгохын тулд цаасыг 2 хувааж нуглан дөрвөн талд нь бөглөх хүснэгт оруулж шалгалтын бүх явцын тухай тэмдэглэхийн хамт шалгалтын үр дүнг тодорхой бичих маягттай байна.

#### (i) Нэгдүгээр нүүр

Гол нэр төрлийн бараа бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээ, ажилчид, тоног төхөөрөмж, удирдлага болон түүний гэр бүлийн байдал зэрэг аж ахуйн үйл ажиллагааны талаар тодорхой мэдээлэл авч болох зүйлийг бичнэ. Өөрөөр хэлбэл, тухайн ААНБ-ийн ажил үйлчилгээний талаар ерөнхийд нь ойлгож мэдэж болохуйцаар тэмдэглэл хийнэ.

#### (ii) Хоёр болон гуравдугаар нүүр

Урьд онуудын тайлан балансны үзүүлэлтүүдийг жил бүрээр харьцуулж болохуйцаар хийнэ. Мөн борлуулалтын ашгийн түвшин зэрэг санхүүгийн харьцаануудыг жил бүрээр харьцуулж болохоор хийж хэвийн бус гарсан үзүүлэлтийг тодорхой бичнэ. Өөрөөр хэлбэл, балансын үзүүлэлт, санхүүгийн харьцаануудыг тулгах замаар санхүү, менежментийн талаар судлахын зэрэгцээ эргэлзээтэй, алдаатай тооцоог илрүүлэх боломжтой байхаар хийнэ.

(iii) Дөрөвдүгээр нүүр

Татварын тайлангийн талаарх заавар зөвлөгөө, хяналт шалгалтын явц, үр дүн, хойшид анхаарах зүйлийг тодорхой бичнэ. Өөрөөр хэлбэл, хяналт шалгалтын явц, түүний үнэлэмж ойлгомжтой байхаар тэмдэглэл хийнэ.

### 3.2.5 Хяналт шалгалтын аргыг сайжруулах

Өөрөө татвараа тодорхойлох системд ААНБ-ын тайлангаар тодорхойлсон татвар ногдох орлогын дүн болон татварын хяналт шалгалтаар тогтоосон дүнгийн хооронд зөрүү гарах тохиолдол байдаг. Уг зөрүү олон шалтгаанаас болж гарах ба татвар төлөгч болон хяналт шалгалтын байцаагчийн хоорондын бодит баримтын талаарх ялгаатай ойлголт, хууль тогтоомжийн зөрүү тайлбараас болж үүсэх явдал түгээмэл байдаг.

Өөрөө татвараа тодорхойлох систем нь ААНБ татвар ногдох орлогоо өөрөө тодорхойлон сайн дураар татварын тайлан гаргаж татвар төлөх систем бөгөөд энэ системийн талаар үнэлэлт дүгнэлт өгч болох хэдий ч татварын хууль тогтоомжууд нь ихэвчлэн нэлээн ээдрээтэй ойлгоход хэцүү байдаг тул бүх татвар төлөгч үнэн зөв ойлгож зохих ёсоор татвар төлдөг гэж хэлэхэд хүндрэлтэй. Өөрөөр хэлбэл бүх татвар төлөгч үнэн зөв ойлгож татвар төлөх баталгаа байдаггүй. Мөн татварын хуулинд нийцсэн татварын тайлан боловсруулж татвар төлдөггүй аж ахуйн нэгж олон байдаг. Энэ асуудлыг зохицуулахгүй тохиолдолд татварын эрх тэгш зарчим алдагддаг. Монгол улсад татварын тайлан гаргаж татвар төлдөггүй аж ахуйн нэгж олон байгаа нь татварын эрх тэгш зарчмыг алдагдуулж байна.

Татварын хяналт шалгалт нь татвар төлөгчийн тодорхойлсон татвар ногдох орлогын дүн татварын хууль тогтоомжинд нийцэж байгаа эсэхийг шалгахад голлон чиглэх ба хяналт шалгалтын шаардлага ч үүнд оршдог.

Татварын хяналт шалгалтыг үр дүнтэй, бүтээмжтэй хийхэд татварын нотлох баримт мэдээлэл хэрэгтэй байдаг. Гэтэл Монгол улсад өнөөгийн байдлаар татварын нягтлан бодох бүртгэлийн тогтолцоо төдийлөн хэвшээгүй, татварын нотлогоо баримт олж авах ашиглах систем зохих түвшинд бүрэлдэж тогтоогүй байна. Үүний улмаас татварын шалгалтыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байдаг. Энэхүү системийг эдийн засгийн салбарт бүхэлд нь нэвтрүүлж чадвал оновчтой татварын хяналт шалгалт хийх боломжтой болно. Мөн татвар төлөгчийн хувьд ч гэсэн татварын хяналт шалгалтанд өөрийн зүгээс гаргах нотлогоо баримт болох бөгөөд татварын албаны хувьд хяналт шалгалт хийхгүй байж болох давуу талтай.

#### *(1) Татварын шалгалтын аргыг олон төрөлжүүлэх*

Татварын шалгалтаар ААНБ-ын орлогын албан татварын тайлан татварын хууль тогтоомжинд нийцэж байгаа эсэхийг шалгах боловч татварын

байцаагчдын тоо, цагийн боломж зэргээс болж үүнийг бүрэн дүүрэн хэрэгжүүлэх боломжгүй байдаг.

Иймд татварын шалгалтыг тухайн арга, зорилготой нь уялдуулан баяжуулах шаардлага гардаг бөгөөд дор дурдсанчлан хяналт шалгалтыг албадан шалгалт, онцгой шалгалт, татвар төлөгчийн зөвшөөрөлтэйгээр хийгдэх шалгалт, хялбарчилсан шалгалт гэж ангилдаг.

( i ) Албадан шалгалт

Албадан шалгалт гэдэг нь татварын хэрэг зөрчилд сэжиглэгдэж байгаа тохиолдлыг тодруулах шаардлагатай вед хийх шалгалт юм. Уг шалгалтыг «хэрэг бүртгэл» гэж хэлж болох бөгөөд дор дурдсан ердийн хяналт шалгалттай адил аргаар хийнэ. Гэхдээ шүүх байгууллагаас зөвшөөрөл авсаны үндсэн дээр албадан шалгалт хийх, эд хөрөнгө битүүмжлэх арга хэмжээ авч болох ба татвар төлөгчийн татварын тайланг шалгаад зогсохгүй тухайн татвар төлөгчийн хэргийг шүүх прокурорт шилжүүлэх зорилгоор хийгддэг.

Урьдчилан нууц тандалт хийх замаар олж тогтоосон нотлох баримтанд тулгуурлан ААНБ-ийн төв болон салбар, вйлдвэр, захиралын гэр орон, харилцагч байгууллага болон банк зэрэг санхүүгийн байгууллагад нэгэн зэрэг хяналт шалгалт (шалган байцаалт) хийж эхлэнэ. Энэхүү шалгалтын вед «албадан шалгалт хийх, эд хөрөнгө битүүмжлэх зөвшөөрлийн бичиг» гаргуулж нэлээн хүчтэй шалгалт хийдэг.

( ii ) Ердийн шалгалт

Ердийн шалгалт нь татвар төлөгчийн хариу туслалцаатайгаар татвар төлөгчийн зөвшөөрлийг авч санхүүгийн тайлан, нотлох баримт шалгах, асуулт тавих замаар хийгддэг. Ердийн шалгалтаар газар дээрх байдалтай танилцах, санхүүгийн бичиг баримтын шалгалт хийх ба татвар төлөгчийн талаар бүрэн гүйцэд мэдэж авах боломжгүй байх явдал байдаг.

( iii ) Онцгой шалгалт

Ердийн хяналт шалгалт нь албадан шалгалттай харьцуулахад хяналт шалгалтыг бүрэн дүүрэн хийх боломжоор хязгаарлагдмал байдаг. Иймд албадан шалгалт болон ердийн шалгалтын завсрын шалгалт буюу онцгой шалгалт хийдэг.

( iv ) Хялбарчилсан шалгалт

Хялбарчилсан шалгалтыг мөн явцуу хүрээний шалгалт гэж нэрлэдэг. Өөрөөр хэлбэл, татвар төлөгчийн тодорхой нэг үзүүлэлтийг сонгож шалгалт хийдэг. Ийм учраас шалгалт хийх хугацаа харьцангуй богино байдаг.

(2) Туршлага солилцох уулзалт

Жил бүр тухайн онд хийгдсэн хяналт шалгалтын дотроос шинэлэг оновчтой аргаар хийгдсэн бөгөөд вйлдвэр, вйлчилгээний хүрээнд түгээмэл гардаг татварын хэрэг зөрчил илрүүлсэн шалгалтын талаар татвар албад тус бүр «оновчтой хяналт шалгалтыг судлах уулзалт» зохион байгуулж хяналт шалгалтын арга барилын талаар санал солилцож нэгдсэн нэг ойлголттой болохыг эрмэлзэхийн зэрэгцээ тухайн шалгалт хийсэн байцаагчийг сурталчлах, татварын хяналт шалгалтын идэвх санаачлагыг дээшлүүлэх, хяналт шалгалтын арга барилыг судлах тогтолцоо бүрдүүлнэ.

Уг уулзалтаар санал болгож дэвшүүлсэн асуудал сайтай, онцгой шинэлэг аргаар их хэмжээний зөрчил илрүүлсэн шалгалтыг сонгоно. Түүнчлэн бусад татварын байцаагчдийн мэдлэг, боловсролыг дээшлүүлэхэд үлгэр жишээ болгох үүднээс тодорхой нэг вйлдвэр, вйлчилгээний төрөл, цар хүрээнд баригдалгвйгээр аль болох өргөн хүрээнд олон талаас нь судалсаны үндсэн дээр туршлага солилцох уулзалтаар хэлэлцэх шалгалтыг сонгоно.

Уулзалтын үеэр хяналт шалгалтын байцаагч өөрийн хийсэн шалгалтын тухай танилцуулж, түүнд илтгэл тавих боломж олгож ийнхүү илтгэл тавих нь тухайн байцаагчийн хувьд нэр төрийн хэрэг байхуйцаар сурталчилна.

*(3) Татвар төлөгчдөд зөвлөгөө заавар өгөх системийг боловсронгуй болгох*

Зөвхөн хяналт шалгалт хийгээд зогсохгүй татвар төлөгчдөд зөвлөгөө өгч тэднийг удирдах ажлыг зэрэгцүүлж хийнэ. Татварын талаарх мэдлэг хомс аж ахуйн нэгж олон байх тул татварын хяналт шалгалтаар хэрэг зөрчил илрүүлэхийн өмнө ийм зөрчил гаргадаг татвар төлөгчийг татварын тайлангаа үнэн зөв гаргадаг болгож сургах нь чухал бөгөөд үүний тулд татвар төлөгч тайлан гаргах үед ойлгоогүй зүйл гарвал түүнд туслах зорилгоор үнэ төлбөргүй татварын зөвлөгөө өгдөг байх хэрэгтэй.

Тухайлбал, шинээр вйл ажиллагаа явуулж буй ААНБ болон адил төрлийн вйл ажиллагаа эрхлэгч татвар төлөгчдөд түгээмэл тулгардаг бэрхшээлтэй асуудал, татварын тайлан гаргах арга, урьд онуудад олон ажиглагдсан татварын буруу зөрүү ойлголт зэргийг танилцуулж хойшид энэ мэт алдаа зөрчил гаргахгүй байх талаар заавар зөвлөгөө өгнө.

**3.2.6 Баримт мэдээллийн системийг бий болгох, түүнийг үр дүнтэй ашиглах нь**

Гаргавал зохих тайлангийн тоо хэмжээг хадгалахын тулд үнэн зөв хяналт шалгалт хийхийн зэрэгцээ татвар төлөгчийн вйл ажиллагаа, эд хөрөнгийн талаар баримт мэдээлэл цуглуулна.

Татварын албанаас татвар ногдуулалтыг хийдэг системд татвар төлөгчийн талаарх мэдээлэл төдийлөн чухал биш. Харин татвараа өөрөө тодорхойлох системд бүх татвар төлөгчдөд хяналт шалгалт хийх

боломжгүй тул мэдээлэлийн ач холбогдол их байдаг. Татварын удирдлага баримт мэдээлэлийн энэхүү үүргийг газар дээрх хяналт шалгалт болон тайлангийн түвшинг барьж байхад ашиглах хэрэгтэй.

Баримт мэдээллийн ашиглагдах хүрээ, хэмжээ нь тайлангийн түвшинд нөлөөлөөд зогсохгүй шалгалтын объектийг сонгоход хэрэг болдог. Иймд баримт мэдээлэлийн системийн арга хэлбэрийн талаар сайтар судлах хэрэгтэй.

- (1) Баримт мэдээлэл цуглуулах, үр дүнтэй ашиглахад боловсон хүчний зохицуулалт хийх

Татварын хяналт шалгалтыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд баримт мэдээлэл цуглуулж ашиглах явдал чухал байдаг. Иймд мэдээлэл цуглуулах болон ашиглах тогтолцоог цэгцтэй болгоход анхаарах хэрэгтэй.

Тухайлбал татварын бүх шатны албад «мэдээлэл харицусан ажилтан» томилж татварын хяналт шалгалтанд шаардлагатай мэдээлэл олж авах, цуглуулах, дүн шинжилгээ хийх ажлыг зохицуулна. Түүнчлэн эдгээр мэдээлэлийг ашиглах тогтолцоог нийт улсын хэмжээнд харилцан холбоотойгоор өргөн хүрээнд мөн зохион байгуулалттайгаар хэрэгжүүлж мэдээлэл олж нээх, цуглуулах, дүн шинжилгээ хийх, харилцан солилцох системийг бий болгоно.

- (2) Бүрдүүлсэн баримт, мэдээллийг ашиглах арга хэлбэр  
Гадны эх үүсвэр бүхий баримт нотолгоо нь харьцангуй найдвартай байдлын түвшин өндөр байдаг тул хяналт шалгалтын сонголт, шалгалтын бэлтгэл ажлын явцад ашигладаг. Өөрөөр хэлбэл, татвар төлөгчийн үйл ажиллагааг нотлох баримт болохын хувьд хяналт шалгалтын объектийг сонгоход шийдвэрлэх хүчин зүйл болдог.

Татварын шалгалтын явцад цуглуулсан баримт мэдээлэл болон санхүүгийн тайланг харьцуулах нь тайлангаас гадуурх борлуулалтын орлого, зохиомол худалдан авалт зэрэг хэрэг зөрчлийг илрүүлэхэд тус дөхөм болдог.

Энэ нь менежментийн дүн шинжилгээ хийх зэрэг судалгааны аргатай харьцуулбал шууд бөгөөд оновчтой арга тул өргөн хэрэглэх хэрэгтэй.

- (3) Цуглуулах шаардлагатай баримт мэдээллийн агуулга, арга барил  
Бүх төрлийн албан ёсны нотлох баримт, тухайлбал ААНБ байгуулагдсан тухай бичиг баримт, борлуулалт, худалдан авалт, буцаан олголтын тухай мэдээлэл, хяналт шалгалтын үеэр цуглуулсан баримт мэдээлэлийг боломж алдалгүй ашиглаж бодит татвар ногдуулалт хийх, баримтжуулахад чухал байдаг. Эдгээр цуглуулсан мэдээлэлийг нийт улсын хэмжээнд татварын албад хооронд солилцох системийг нэвтрүүлнэ.

Хяналт шалгалтын бэлтгэл ажлын хүрээнд нотлох баримт мэдээлэлээр санхүүгийн тайланг шалгах нь тайлан үнэн зөв эсэхийг тогтоох, мөн хяналт шалгалтын объектын сонголтыг оновчтой болгоход чухал байдаг.

Хяналт шалгалтанд зарцуулагдах хугацаа хязгаарлагдмал байдаг ба татвар төлөгчийн үйл ажиллагаа нарийн ээдрээтэй байх тохиолдол байдаг тул шалгалтыг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд санхүүгийн тайланд дүн шинжилгээ хийх, шаардлагатай баримт мэдээлэлийг олж цуглуулах явдал чухал байдаг. Иймд шалгалтын явцад бүхий л боломжийг ашиглан ашигтай мэдээлэл олж авахын зэрэгцээ хэвлэл мэдээлэлийн хэрэгслээр нэвтрэх ААНБ-ийн зар сурталчилгааг цуглуулна. Цуглуулах баримт мэдээлэлийн агуулга болон нотлох баримт, мэдээлэл цуглуулах арга хэлбэрийн тухай дор дурдав.

( i ) Албан ёсны баримт

Албан ёсны квитанцийн системийг нэвтрүүлэх нь тохиромжтой. Татварын албанд тушаах квитанцанд тулгуурлан баримт мэдээлэл бүрдүүлэх үүрэг өгч мэдээлэл цуглуулахад анхаарна.

( ii ) Татварын хяналт шалгалтын явцад мэдээлэл цуглуулах

Татварын хяналт шалгалтын явцад зөвхөн тухайн татвар төлөгч төдийгүй тайланд тусгагдаагүй гэж үзэж болох харилцагч байгууллагыг сонгож тэдний хоорондын арилжааны дүн, агуулага, арилжаа хийгдсэн хугацааны талаар мэдээлэл боловсруулна.

( iii ) Холбогдох яамд газраас мэдээлэл авах

Орон сууц худалдан авсан тухай бүртгэлийн бичиг баримт зэрэг хяналт шалгалтын ажилд тус дэм болохуйц холбогдох яамд газар дахь мэдээлэлийг баримтжуулахад анхаарна. Бусад яамд газартай нягт харилцаа холбоо тогтооход анхаарна.

**3.2.7 Хяналт шалгалтын байцаагчийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх нь**

Бүх төрлийн сургалт (татварын нягтлан бодох бүртгэлийн талаарх мэдлэг, мэдээлэл цуглуулах арга барил болон түүний ач холбогдол, нягтлан бодох бүртгэлийн бичиг баримтын шалгалт, татварын нотлох бичиг баримт, хяналт шалгалтын арга технологийн сургалт)-аар дамжуулан хяналт шалгалтын аргыг боловсронгуй болгоход анхаарна. Мөн тэргүүний татварын байцаагчийн ажлын арга барилыг бусдад дамжуулж тухайн арга технологийг хамтран ашигладаг болгохын тулд өмнө өгүүлсэн туршлага солилцох хурал зохион байгуулж илтгэл гаргахын зэрэгцээ сурталчилгаа явуулна.

**3.2.8 Тайлан гаргадаггүй татвар төлөгчийг илрүүлэх нь**

Тайлан гаргадаггүй татвар төлөгчийг илрүүлэхийн тулд аж ахуйн нэгж, нөхөрлөлийн бүртгэл тооцоо, гаалийн байгууллагад бүртгэгдсэн экспортын чиглэлийн вйлдвэрийн жагсаалт, татварын хөнгөлттэй бодлого эдэлдэг татвар төлөгчийн хүснэгт, онцгой хяналт шалгалт зэргийг ашиглана.

Дээр дурдсан хяналт шалгалт нь ААНБ-ын албан татварт хамаарах бөгөөд НӨАТ-ын хяналт шалгалтыг нэгэн зэрэг хийх нь илүү үр дүнтэй байх болно.



## Бүлэг 4



#### 4. Хөх тайлангийн системийг нэвтрүүлэх нь

##### 4.1 Хөх тайлангийн системийн ач холбогдол

Хөх тайлангийн систем нь арилжаа гүйлгээний данс бүртгэлд тулгуурлан орлогын тайлангаа үнэн зөв гаргадаг хувиараа ажил үйлчилгээ эрхлэгч, үл хөдлөх хөрөнгө түрээслэн зээлдүүлэх үйлчилгээ эрхэлдэг хувь хүн, ( дор «хувиараа ажил эрхлэгч» гэх), аж ахуйн нэгж, байгууллагад данс бүртгэлгүй татвар төлөгчөөс давуу эдлүүлэх татварын хөнгөлөлтийн систем юм. Хөх тайлангийн системд хамрагдах татвар төлөгчийг хөх тайлан гаргагч гэж хэлдэг.

Хөх тайлангийн системд тулгуурлан орлогын тайлан гаргах тохиолдолд хувь хүн, аж ахуйн нэгж ялгаагүй ажил үйлчилгээ эрхлэгч татвар төлөгч бүр арилжаа гүйлгээний данс бүртгэлд үндэслэн сайн дураар орлогоо тодорхойлон тайлан гаргадаг.

Монгол улсын өнөөгийн татварын хууль тогтоомжоос үзвэл Татварын Ерөнхий хуулийн 9-р зүйлийн "татвар төлөх журам"-ын 1 дүгээр хэсэгт «татварыг тайлан буюу татвар тодорхойлох хуудсаар, эсхүл суутгал хийх замаар ногдуулж...» гэж заасан байдаг. Тус хуулийн 10-р зүйлийн "татварын төлөгчийн үүрэг" 2-р хэсэгт "татвар ногдуулах, төлөхтэй холбогдсон тооцоо, мэдээ тайланг тогтоосон хугацаанд татварын албанд ирүүлэх», 3-р хэсэгт «анхан шатны болон нягтлан бодох баримт бүртгэлийг тогтоосон журмын дагуу хөтөлж, санхүү аж ахуйн үйл ажиллагааны тайлан тэнцэл гаргах» гэж заажээ.

Мөн татвар ногдуулалт, төлөлтөд хяналт тавих татвар хураах тухай хуулийн 8-р зүйлийн "татвартай холбогдсон баримт бүрдүүлэх, бүртгэл хөтлөх хадгалах " 1-р хэсэгт «татвар төлөгч нь хууль тогтоомжийн дагуу татвар ногдох зүйл, төлөх татварын хэмжээг тодорхойлохтой холбогдсон баримтыг бүрдүүлж, аж ахуйн нэгж, байгууллагын тухайд нягтлан бодох бүртгэл иргэнийн тухайд энгийн бүртгэл хөтөлнө», 15-р зүйлд "татварын ногдлыг тодорхойлох, хянан шалгах" 1-р хэсэгт "татвар төлөгч холбогдох баримт бүртгэлд үндэслэн татварын ногдлоо өөрөө тодорхойлон татварын тайланд тусгана ...» гэж тус тус заасан байдаг.

Эдгээр заалтуудын дагуу Монгол улсад Хүн амын орлогын албан татварын хууль, аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын хуульд нэгэн адил татвараа өөрөө тодорхойлон төлөх систем үйлчилдэг бөгөөд орлогын тайлан гаргахдаа татвар төлөгч өөрөө анхан шатны бүртгэл зэрэг данс бүртгэлд тулгуурлан татвар ногдох орлогоо тодорхойлж байна. Гэвч бодит байдал дээр татварын тогтолцоо бүрдээд дөнгөж 10 жил өнгөрч байгаа бөгөөд ихэнх татвар төлөгчдийн татварын болон нягтлан бодох бүртгэлийн талаарх ойлголт мэдлэг хомс, түүнчлэн татвар төлөх ухамсар төлөвшөөгүй зэргээс шалтгаалан нийт татвар төлөгчдөд бүртгэл хөтөлж хэвшүүлэхэд хүндрэлтэй байдаг.

Аль болох олон татвар төлөгчийг данс бүртгэлд үндэслэн тайлан гаргадаг болгож хэвшүүлэхийн тулд хөх тайлангийн системийг нэвтрүүлж тухайн татвар төлөгчдөд төрөл бүрийн татварын хөнгөлөлт үзүүлэх замаар тэднийг урамшуулж дэмжих нь чухал юм.

Ийнхүү хөх тайлангийн систем нь татвараа өөрөө тодорхойлж төлөх системийг хэвшүүлэхэд чухал ач холбогдолтой байдаг.

#### **4.2 Данс бүртгэл хөтлөлтийн өнөөгийн байдал**

Монгол улсад хувиараа ажил үйлчилгээ эрхлэгч болон аж ахуйн нэгж, байгууллагын данс бүртгэл хөтөлж буй байдлаас гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, эсхүл дотоодын томоохон аж ахуйн нэгжүүд данс бүртгэл хөтөлж тайлан баланс гаргадаг. Бусад жижиг дунд үйлдвэрийн хувьд нягтлан бодох бүртгэл тэр бүр сайн хөтөлдөггүй бөгөөд нийт аж ахуйн нэгжийн 10-20% нь л бүртгэл хөтөлдөг гэсэн барагцаа тооцоо байдаг. Хувиараа ажил үйлчилгээ эрхлэгчид ямар нэгэн хэмжээгээр бүртгэл тэмдэглэл хөтөлдөг хэдий ч татварын тооцоо хийх зорилгоор данс бүртгэл хөтөлдөггүй гэж хэлж болно. Энэ нь дор дурдсан шалтгаантай холбоотой.

- 1) Татварын тайлан боловсруулах ажлыг голлон эрхэлдэг мэргэшсэн татварын нягтлан бодогчийн систем нэвтрээгүй, татварын тайлан ердийн нягтлан бодогчоор хийлгэдэг хэдий ч зөвхөн том аж ахуйн нэгж болон татвар төлөгчдийн цөөхөн хэсэг нь нягтлан бодогчид ханддаг.
- 2) Ихэнх татвар төлөгчдийн нягтлан бодох бүртгэлийн талаарх мэдлэг дутмаг байдаг.
- 3) Хувиараа ажил үйлчилгээ эрхлэгчдийн дотроос дор 10 дугаар хэсэгт өгүүлэх орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил үйлчилгээнд хамаарах татварт төлөгчид (Орлогыг нь тодорхойлох боломжгүй татвар төлөгчдийн тоог нарийн гаргаж чадаагүй байгаа бөгөөд хувиараа ажил үйлчилгээ эрхлэгчдийн ойролцоогоор талаас илүү хувь нь хамрагдаж байна) нь орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэдийн орлогод албан татвар ногдуулах тухай хуулийн дагуу сар тутам тогтмол хэмжээний татвар төлдөг ба эдгээр иргэдээс татвар ногдох орлого тодорхойлоход хэрэгтэй данс бүртгэл шаарддаггүй.
- 4) Зарим том аж ахуйн нэгжийг эс тооцвол ихэнх арилжаа бэлэн мөнгөөр хийгддэг бөгөөд нарийн данс бүртгэл хөтөлдөггүй.
- 5) Ихэнх татвар төлөгчийн татвар төлөх ухамсар дорой байгаагаас сайн дураар татвараа тодорхойлж төлөх дадал хэвшээгүй, бүртгэл хөтлөхдөө хойрго ханддаг.

#### **4.3 Хөх тайлангийн системийг нэвтрүүлэх тухай**

[1] Хөх тайлангийн систем нэвтрүүлэх цаг хугацааны талаар

Дээр 4.2-т дурдсан том татвар төлөгчөөс бусад ихэнх татвар төлөгчид татвар ногдох орлогоо тодорхойлох бүртгэл хөтөлдөггүй, хөтлөх ухамсар сул дорой байдалтай хэвээр байна. Ийм нөхцөлд хөх тайлангийн системийг нэвтрүүллээ гэж бодоход данс бүртгэлд тулгуурлан тайлангаа зөв гаргадаг татвар төлөгчдийн тоог нэмэгдүүлэх бодлого үр дүнтэй хэрэгжинэ гэж найдахад хэцүү.

Хөх тайлангийн татварын хөнгөлөлтийн тухайд, Япон улстай харьцуулахад:

- ① Монгол улсад гаргадаг хувь хүн, аж ахуйн нэгж, байгууллагад нэгэн адил татварын хөнгөлөлт эдлүүлэх талаар холбогдох хууль, тогтоомжийн заалт байхгүй.
- ② Япон улсын хөх тайлан гаргадаг хувиараа ажил үйлчилгээ эрхлэгчдийн хөдөлмөрийн хөлсийг зардалд оруулж тооцдог татварын давуу хөнгөлөлт нь Монгол улсын хүн амын орлогын албан татварын хуулийн гэр бүлийн гишүүдэд олгосон хөдөлмөрийн хөлсийг зардалд оруулж тооцох тухай заалттай онцын зааг ялгаа байхгүй.
- ③ Хөх тайлан гаргадаг алдагдалтай ажилласан татвар төлөгчийн татвар ногдох орлогоос алдагдлын дүнг буцаан олгох, дараагийн тайлант хугацаанд шилжүүлж тооцдог арга нь (3)(ii)-ийг харна уу ) данс бүртгэлээ тогтмол үнэн зөв хөтлөж нарийн тооцоо хийхийг шаарддаг тул татвар төлөгчийн хувьд түвэгтэй байж болох юм. Иймд татвар төлөгч ойлгож хүлээж авахад амархан хөнгөлөлтийг үзвэл голлон татвар ногдох орлогоос хасалт хийх зэрэг хэд хэдэн хөнгөлөлт байдаг.

Хөх тайлангийн татварын хөнгөлөлтийн давуу талыг ашиглан татвар төлөгчдийн данс бүртгэл хөтлөлтийг урамшуулан татварын тайлан гаргалтын хэмжээг бага ч болов нэмэгдүүлж татвар ногдох орлогоо үнэн зөв тодорхойлдог болгож хэвшүүлэхэд дөхөм болж чадахгүй бол хөх тайлангийн татварын хөнгөлөлт үр дүнтэй хэрэгжих боломжгүй.

Түүнчлэн хүн амын орлогын албан татварын тухай авч үзвэл өмнө дурдсан татварын эрх тэгш зарчим алдагдаж байдаг орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэдийн орлогод албан татвар ногдуулах тухай хуулийн тогтмол хэмжээгээр татвар ногдуулах тогтолцоог өөрчлөх, эсвэл хүчингүй болгохгүй тохиолдолд уг хуульд хамрагдахгүй татвар төлөгчид татварын албанд итгэж хөх тайлангийн системийг хүлээн зөвшөөрч хэрэгжүүлэхэд хүндрэлтэй.

Иймд хөх тайлангийн системийг дор дурдсан аргаар нэвтрүүлэх нь зүйтэй.

- ① Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэдийн орлогод албан татвар ногдуулах тухай хуулиар тогтмол хэмжээгээр татвар ногдуулдаг тогтолцоог өөрчилж эсвэл халах, бүх хувиараа ажил үйлчилгээ эрхлэгчид данс бүртгэл хөтөлж орлого, зарлагаа тооцож татвар ногдох орлогоо тодорхойлдог болгож хэвшүүлэх

- ② Данс бүртгэл хөтлөөгүй хувиараа ажил үйлчилгээ эрхлэгч болон аж ахуйн нэгж, байгууллагад татварын алба жишиг татвар ногдуулах замаар татвар ногдуулалтын ажлыг бэхжүүлэх, данс бүртгэл хөтлөөгүй хэн болов ч татвар төлөх үүргээс чөлөөлөгдөхгүй, харин ч эсрэг үр дүн авчирч болно гэдгийг ойлгуулж ухамсарлуулахад чиглэсэн татварын хяналт шалгалтыг хийх
- ③ Одоо яригдаж байгаа кассын машины систем болон албан ёсны квитанцийн системийг нэвтрүүлж хэвшүүлэх зорилгоор татвар ногдуулалтанд шаардлагатай баримт материалыг цуглуулах, олж тогтоох ажлыг эрчимжүүлэх
- ④ Татвар төлөгчдийн үүрэг хариуцлагыг дээшлүүлэхэд чиглэсэн мэдээлэл сурталчилгааны ажлыг тогтмол зохион байгуулах, тэдний нягтлан бодох бүртгэлийн талаарх мэдлэгийг өргөжүүлэх зэрэг арга хэмжээ авч тодорхой үр дүнд хүрсэн үед хөх тайлангийн системийг нэвтрүүлэх шийдвэр гаргах хэрэгтэй.

## [2] Хөх тайлан гаргах татвар төлөгчдийн хөтлөх ёстой данс бүртгэл

Хөх тайлангийн системийг нэвтрүүлсэн тохиолдолд хөх тайлан гаргах татвар төлөгчдийн хөтлөх данс бүртгэлийг тогтоохдоо ажил үйлчилгээний цар хэмжээ, төрөл, данс бүртгэл хөтлөх чадвар зэргийг харгалзан дараах гурван хэсэгт хуваана.

### 1) Зохих шаардлагын дагуу данс бүртгэл хөтлөх татвар төлөгч

- Жилийн эцсийн тайлан баланс, орлого зарлагын тайлан гаргахад шаардагдах нягтлан бодох бүртгэлд (давхар бичилт) тулгуурлан дараах данс бүртгэл хөтлөнө. Үүнд:
  - Анхан шатны бүртгэл
  - Ерөнхий дэвтэр (хавсралт болох туслах дэвтрийг оруулна)
  - Бараа материалын бүртгэл гэх мэт бусад шаардлагатай данс бүртгэл
- Аж ахуйн нэгж, байгууллага нь дээрх данс бүртгэл заавал хөтлөх бөгөөд харин хувиараа ажил үйлчилгээ эрхлэгч нь өргөдөл гаргасны үндсэн дээр хөтөлж болно.

### 2) Энгийн бүртгэл хөтлөх татвар төлөгч

- Дараах данс бүртгэл хөтөлнө. Үүнд:
  - Кассын дэвтэр
  - Дансаарх авлагын дэвтэр
  - Дансаарх өглөгийн дэвтэр
  - Зардлын дэвтэр
  - Үл хөдлөх хөрөнгийн дэвтэр болно.
- Хувиараа ажил үйлчилгээ эрхлэгч өргөдөл гаргаж хөтөлж болно.

### 3) Мөнгөн суурьт зарчмын дагуух данс бүртгэл

- Орлого, зарлагын тооцоог бэлэн мөнгө хүлээж авсан, эсвэл бэлэн мөнгөөр төлбөр хийсэн үед хийх ба дараах данс бүртгэл хөтлөнө. Үүнд  
Кассын дэвтэр  
Үндсэн хөрөнгийн дэвтэр орно.
- Урьд жилүүдийн орлого бага (жишээ нь 600мянган₮-с доош орлоготой бол) хувиараа ажил үйлчилгээ эрхлэгч хөх тайлан гаргах өргөдөл гаргана.

Үндэсний татварын ерөнхий газар дээр дурдсан 1), 2) болон 3) гэсэн гурван төрлийн данс бүртгэлийн маягтыг ямар ч татвар төлөгч хялбар хөтлөж болохуйцаар хэвлэж гаргаад хямд үнээр татвар төлөгчдөд худалдах нь зүйтэй юм. Ийм замаар данс бүртгэл хөтлөх зааварчилгаа зөвлөгөө өгөх ажлыг сайжруулах боломжтой болно. Мөн боломжтой бол Японы «хөх тайлангийн татвар төлөгчдийн холбоо» шиг олон нийтийн байгууллага байгуулж татвар төлөгчид өөрсдөө татварын албатай хамтран ажиллаж данс бүртгэлд тулгуурлан үнэн зөв тайлан гаргах боломжтой татварын орчин бүрдүүлэхэд анхаарах хэрэгтэй.

### [3] Хөх тайлангийн хөнгөлөлт

Хөх тайлангийн хөнгөлөлтийг тухайн жилийн төсөв санхүүгийн байдал, аж ахуйн нэгж, байгууллага болон эдийн засгийн нөхцөл байдал зэргээс хамааран бодлогын чанартай шийддэг бөгөөд дор гол хөнгөлөлтүүдийг дурдав.

#### 1) Хөх тайлангийн онцгой хөнгөлөлт

Үйл ажиллагааны ашгийг тооцох үед хасалт хийхдээ тухайн татвар төлөгчийн хөтлөх данс бүртгэлийн төрлөөс хамааран урьдчилан хуулинд зааж тогтоосон хасалт хийх хэмжээг тогтоодог.

Жишээлбэл, давхар бүртгэл хөтлөх татвар төлөгчийн хувьд 50 мянган ₮, энгийн бүртгэл хөтлөх төтөр төлөгчийн хувьд 30 мянган ₮, мөнгөн суурьт зарчмын дагуу бүртгэл хөтөлдөг татвар төлөгчид 10 мянган ₮-ийн онцгой хөнгөлөлт эдлүүлэх гэх мэтчлэн тухайн татвар төлөгчийн хөтлөх бүртгэлийн түвшнээс нь хамааран ялгавартайгаар хасалт хийх арга юм.

Энэ тохиолдолд хөх тайлангийн онцгой хасалт хийх зааг ялгааг тухайн ажил үйлчилгээний ашгийг тооцох арга дотор зааж өгвөл дараах байдлаар гарна.

Борлуулалтын орлого - борлуулалтын өртөг - бусад зардал - хөх тайлангийн онцгой хасалт = үйл ажиллагааны ашиг

- 2) Алдагдлыг дараагийн тайлант хугацаанд шилжүүлж татвар ногдох орлогоос хасч тооцох, өмнөх оны татвар ногдох орлогоос хасч татварын илүү төлөлтийг буцаан олгох

Дараагийн тайлант хугацаанд шилжүүлж тооцох гэдэг нь тухайн жилийн үйл ажиллагааны ашиг ( боруулалтын орлого - борлуулалтын өртөг - бусад зардал ) хасах буюу алдагдалтай гарсан тохиолдолд ( энэ тохиолдолд орлогыг нь «цэвэр алдагдал» гэх ) хөх тайлан гаргах татвар төлөгчийн алдагдлыг дараагийн 3 жилийн дотор ашигтай ажилласан жилийн татвар ногдох орлогоос нь хасч тооцох онцгой хөнгөлөлтийн арга юм.

Өмнөх оны татвар ногдох орлогоос тухайн жилийн алдагдлын дүнг хасч илүү төлсөн татварыг буцаан олгох гэдэг нь цэвэр алдагдлыг ашигтай ажилласан өмнөх оны татвар ногдох орлогоос хасч өмнөх оны төлсөн татварын зарим хэсгийг буцаан олгох хөнгөлөлтийн арга юм. Хөх тайлан гаргах татвар төлөгч нь тухайн үеийн байдлаас хамааран татвар ногдох орлогоос алдагдлын дүнг хасч татварын илүү төлөлтийг буцаан олгох, алдагдлыг дараагийн тайлант хугацаанд шилжүүлж татвар ногдох орлогоос хасч тооцох аргын аль нэгийг сонгоно.

### 3) Татвар ногдуулах процедур

Жишээлбэл, «хөх тайлан гаргадаг татвар төлөгчид татвар ногдуулахдаа данс бүртгэлийн шалгалт хийлгүйгээр жишгээр татвар ногдуулахыг хүлээн зөвшөөрөхгүй», «хөх тайлан гаргах татвар төлөгчид татвар ногдуулахдаа мэдэгдэх хуудсанд уг шалтгаан үндэслэлийг заавал бичнэ» гэх мэтчлэн татвар ногдуулалтын процедурын тал дээр хөнгөлөлт байж болох юм.

### 4) Бусад

Жишээлбэл, найдваргүй авлагын нөөц, ажлаас халагдсаны нөхөн олговор болон цалингийн нөөц зэрэг бүх төрлийн нөөцийг зөвхөн хөх тайлан гаргадаг татвар төлөгчид хүлээн зөвшөөрнө, тодорхой техник тоног төхөөрөмжийн хувьд хөх тайлан гаргах татвар төлөгчийн ерөнхий элэгдлийн зардлаас гадна «тусгай элэгдлийн зардал» -д оруулж тооцох шаардлагатай зардлыг татвар ногдох орлогоос хасахыг хүлээн зөвшөөрөх гэх мэт хөнгөлөлт байж болно.

### [4] Хөх тайлангийн процедур

Түүнчлэн хөх тайлангийн системийг нэвтрүүлэх тохиолдолд тайлан гаргах бүх төрлийн процедурыг цэгцлэх шаардлагатай бөгөөд санаа авхуулах үүднээс дараах зүйлийг дурдаж болно.

#### 1) Хөх тайлан гаргах өргөдөл

Татвар төлөгч «хөх тайлан гаргах өргөдөл»-ийг харъяалагдах татварын албанд гаргаж «хөх тайлан гаргах зөвшөөрлийн хуудас» авснаар хөх тайлан гаргаж болно. Хөх тайлангийн өргөдөл гаргах хугацааг хөх тайлан гаргахаар бэлдэж буй тухайн жилийн ( тайлант жил) 2 сарын 10-ний дотор ( өмнөх тайлант жилийн орлогын тайлан гаргах хугацаа ) гаргасан байхаар тогтоох хэрэгтэй. Харин шинээр ажил үйлчилгээ эхлэх татвар төлөгч тухайн ажил үйлчилгээ эхэлснээс хойш хоёр сарын дотор



хөх тайлангийн өргөдөл гаргана. Мөн хөх тайлан гаргах өргөдөлд хаяг, ( хувь хүний оршин суух хаяг, эсвэл аж ахуйн нэгж, байгууллагын толгой компанийн хаяг ), үйл ажиллагааны нэр төрөл, хувираа ажил, үйлчилгээ эрхэлж эхэлсэн он сар өдөр, эсвэл аж ахуйн нэгж, байгууллагын байгуулагдсан он сар өдөр зэргээс гадна бүртгэлийн арга (давхар, энгийн, мөнгөн суурьт зарчмын аль нэг аргыг сонгох ) болон хөтлөх бүртгэлийн төрөл (данс, анхан шатны бүртгэл, кассын дэвтэр, дансаарх авлагын дэвтэр, худалдан авалтын дэвтэр, зардлын дэлгэрэнгүй дэвтэр, үндсэн хөрөнгийн дэвтэр зэрэг)-ийг тодорхой бичнэ.

- 2) Хөх тайлан гаргах зөвшөөрлийг хүчингүй болгох  
Хөх тайлан гаргах зөвшөөрөл авсан хэдий ч уг зөвшөөрөл авснаас хойш данс бүртгэлээ хуурамчаар бүрдүүлсэн, хууль тогтоомжинд заасны дагуу хөтлөж хадгалаагүй, орлогын тайлангаа зохих хугацаанд нь тушаагаагүй тохиолдолд татварын алба хөх тайлан гаргах зөвшөөрлийг хүчингүй болгохдоо «хөх тайлангийн зөвшөөрлийг хүчингүй болгох тухай мэдэгдэх хуудас»-нд тухайн зөвшөөрлийг хүчингүй болгох болсон шалтгааныг тэмдэглэж харъяалах татварын албанаас татвар төлөгчид гардуулна.
- 3) Данс бүртгэлийг хадгалах хугацаа  
Данс бүртгэл, бүртгэлийн бичиг баримт, бэлэн мөнгө болон хадгаламжтай холбоотой бичиг баримтын хувьд хадгалах хугацаа нь 7 жил, бусад биичг баримтын хувьд 5 жил байна.
- 4) Хөх тайлан гаргахаа болих  
Татвар төлөгч өөрөө хөх тайлан гаргахаа болихоор шийдсэн бол тухайн тайлант хугацааны дараагийн жилийн 2 сарын 10-ны дотор (орлогын тайлан гаргах хугацаа) «хөх тайлан гаргахаа болих өргөдөл»-г харъяалах татварын албанд гаргана.

## Бүлэг 5

## 5. Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэдийн орлогод ногдуулах албан татвар

### 5.1 Асуудал дэвшүүлэх нь

Монгол улсын хүн амын орлогын албан татварын хуулийн 7-р зүйлийн 4-т «Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэдийн орлогод албан татвар ногдуулах процедурыг засгийн газрын санал болгосноор УИХ шийдвэрлэнэ.» хэмээх заалт байдаг бөгөөд УИХ-аас гаргасан шийдвэрийг үндэслэн Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэдийн орлогод албан татвар ногдуулах тухай хууль батлагдан гарч хэрэгжиж буй билээ.

Тус хуулийн агуулгыг авч үзвэл татвар төлөгч хувь хүн өөрийн эрхлэх тодорхой төрлийн ажил үйлчилгээн дээр ажил гүйлгээ бүрээр болон бүсчилж тогтоосон тогтмол хэмжээний татварыг сар тутам төлснөөр тухайн ажил үйлчилгээнд төлөх тухайн жилийн орлогын татварын тооцоо дуусна гэсэн санаа агуулж байна.

Энэ заалтаар бол энэ хуулинд хамрагдаж буй татвар төлөгчийн ажил үйлчилгээний төрөл нь

- ① Орлого зарлагын гүйлгээ бэлэн мөнгөөр хийгдэж буй
- ② Тодорхой бус тооны олон харилцагчтай
- ③ Татвар төлөгч иргэдийн бүртгэл хөтөлж хэвшсэн байдал болон татварын мэдлэгийн түвшингээс хамааран данс бүртгэл хөтлөхийг шаардахад төвөгтэй байдаг
- ④ Ажил үйлчилгээний хүрээ цомхон, орлого их олдоггүй.
- ⑤ Татварын албаны ажлын ачаалал их байдгаас татвар хураалтыг үр ашигтай явуулах гэсэн шалтгаануудаас болж хүн амын орлогын албан татварын хуулийн дагуу нягтлан бодох бүртгэл тооцоонд тулгуурлан ажил үйлчилгээний орлогыг тооцон гаргах бус харин орлогын их багаас үл хамаарах ажил үйлчилгээний төрөл болон бүс нутгаар ангилан тогтоосон жишиг татвараар татвар төлөлтийг дуусгавар болгох гэсэн санаа агуулж байна.

Уг нь татвараа өөрөө тодорхойлох системийн хүрээнд татвар ногдуулалтын эрх тэгш байдал нь үйл ажиллагааны орлогын бодит тооцоонд үндэслэн тооцож гаргасан орлогод тулгуурлан татварын хэмжээг тогтоосноор хангагдах ёстой билээ.

Гэтэл Монгол улсын Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэдийн орлогод албан татвар ногдуулах тухай хуулинд заасан жишгээр ногдуулах татвар нь татвар төлөгчдийн татварын ачааллын эрх тэгш байдлыг үл хэрэгсэж, татвар төлөгч болон татварын албан дахь амар байдлыг илүүтэйгээр тавьжээ. Ялангуяа, сүүлийн үед ажил үйлчилгээний төрөл болон байршлын таатай нөхцөл байдлаас их хэмжээний орлого олж буй хэрнээ маш бага хэмжээний татвар төлж буй татвар төлөгчийн тоо өсөх хандлагатай байна.

Дээрх нөхцөл байдлын улмаас зарим татвар төлөгчийн зүгээс татвар ногдуулалт эрх тэгш бус байна гэсэн гомдол гарч байгаа бөгөөд цаашилбал татварын албаны татвар хураалтын үйл ажиллагаатай холбоотой эсэргүүцэл ч гарч мэдэх юм. Ялангуяа, хувиараа ажил үйлчилгээ эрхлэгч иргэн олонтой Улаанбаатар хотод патентаар татвар төлөгч, жирийн татвар төлөгчийн хооронд орлогын зааг ялгаа их гарах болсон бөгөөд Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэдийн орлогод албан татвар ногдуулах тухай хуулийн дагуух патентын ногдол нь шударга бус байна гэдэг нь тодорхой болж ирлээ.

Тиймээс Улаанбаатар хотод микроавтобусаар зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэгчдэд татварын байцаагч нар орлогын түүвэр судалгаа хийж, патентаар төлж буй татварын хэмжээ, бодит орлогод ногдох татварын хэмжээ (заримыг нь жишгээр тооцсон)-г хооронд нь харьцуулж үзэхэд бодит орлогод ногдох татварын хэмжээ нь нэг татвар төлөгчийн хувьд дунджаар 4 дахин их хэмжээтэй байгааг тогтоожээ. Эндээс хот дотор зорчигч тээврийн үйлчилгээнд гарч буй микроавтобусны тоог авч үзвэл, хотын төвийн шугамын үйлчилгээнд 1,863, хотын захын шугамын үйлчилгээнд 535 микроавтобус гарч буй тул эдгээр зорчигч тээврийн үйлчилгээ эрхэлж буй хүмүүст бүгдэд нь хүн амын орлогын албан татварын хуулийн дагуу татвар ногдуулбал жилдээ улсын төсөвт нийт 1,087,613 мян төгрөгийн орлого орж ирэх тооцоо гарч байна.

Дээрхээс үзэхэд орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэдийн орлогод албан татвар ногдуулах тухай хуулийг татвараа өөрөө тодорхойлох системийн хүрээнд татвар ногдуулалтыг үнэн зөв хийх үүднээс халах нь зүйтэй бөгөөд үүнтэй холбоотой доорхи 3 саналыг судалж үзэх шаардлагатай байна.

- ① Тус хуулийг нэн даруй халах
- ② Халалгүйгээр хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах, өөрчлөлт оруулах тохиолдолд ямар өөрчлөлт оруулах
- ③ Тус хуулийг хэвээр нь үлдээж зүйл заалтад тайлбар оруулах замаар ялангуяа, татварын эрх тэгш байдлыг илт алдагдуулж буй татвар төлөгч (патентын хэмжээнээс илт өндөр орлого олж буй татвар төлөгч)-д хүн амын орлогын албан татварын хуулийн дагуу татвар ногдуулж болох эсэхийг нягтлан үзэх хэрэгтэй.

## 5.2 Асуудлыг шийдвэрлэх арга зам

### [1] Хуулийг халах тохиолдолд

Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэдийн орлогод албан татвар ногдуулах тухай хуулийг даруй халах тохиолдолд 1-рт өнөөгийн байдлаар татвар төлөгчид нь орлого зарлагатай холбоотой баримт бүртгэл хөтөлдөггүй, ямар нэгэн хэмжээгээр тэмдэглэл хөтөлдөг байсан ч түүнийгээ гаргаж танилцуулдаггүй, 2-рт татвар төлөгчийн татвар төлөх ухамсар тун доогуур зэрэг шалтгаанаас татвар төлөгч өөрөө орлогоо үнэн зөв тодорхойлж тайлагнана гэдэгт найдалтгүй бөгөөд ихэнх татвар төлөгчид татварын тайлан гаргахгүй, эсвэл татвар ногдох орлогоо багаар тодорхойлох болно.

Иймээс татварын тайлан гаргадаггүй, эсвэл татвараа багаар тайлагнадаг татвар төлөгчдөд хяналт шалгалтын байцаагч нарийн шалгалт хийж, жишиг татвар ногдуулах замаар үүнийг шийдвэрлэх шаардлагатай болох хэдий ч цөөн тооны татварын хяналт шалгалтын байцаагчтай өнөөгийн нөхцөлд олон тооны хувиараа аж ахуй эрхлэгчдийг хяналт шалгалтанд хамруулах боломж хомс бөгөөд эндээс татварын орлого буурах нь зайлшгүй болж байна.

Иймээс улсын төсвийн орлогыг нэмэгдүүлэх үүднээс жишиг татварыг төлсөн нөхцөлд л ажил үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгодог болгох нь хэдийгээр орлогын зааг ялгаанаас үүдэх татварын тэгш бус байдлыг бий болгож мэдэх хэдий ч ямар ч байсан наад захын татварыг төлүүлж авах боломжийг бүрдүүлэх бөгөөд мөн юу юунаас илүү жижиг ажил үйлчилгээ эрхэлж буй олон тооны иргэдийг татварт хамруулж, тэдэнд татвар төлөх хүсэл сонирхол төрүүлж чадна гэж үзэж байна.

Гэвч татвар ногдуулалтын тэгш бус байдал нь тийм ноцтой бус тохиолдолд үүнийг тэглээ том асуудал болгох шаардлагагүй бөгөөд дээр өгүүлсэнчлэн их хэмжээний орлого олж буй хэрнээ маш бага хэмжээний татвар төлж буй иргэдийн тоо өсч, энэ талаарх шүүмжлэл бусад татвар төлөгчдийн зүгээс гарч буй тул цаашдаа ард иргэдийн татварын систем болон татварын албанд итгэх итгэл буурч, татвараа өөрөө тодорхойлох системийн хүрээн дэх эрх тэгш татвар ногдуулалтын хэрэгжилтэд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй юм.

Иймээс дээр дурдсан байдлаас сэргийлэх үүднээс одоогийн системийн талаар ямар нэгэн шинэчлэлт өөрчлөлт хийх хэрэгтэй гэж үзэж байна.

### [2] Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэдийн орлогод албан татвар ногдуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тохиолдолд

Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэдийн орлогод албан татвар ногдуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тохиолдолд дараах 3 зүйлийг санал болгож байна.

- 1) Патентын татварт хамрагдах шаардлагатай ажил үйлчилгээний нэр төрлийг нэмж, бүс нутаг байршлын ялгаа ангиллыг эргэн харж, сар тутмын тогтмол хувь хэмжээг өнөөгийн нөхцөлд нийцүүлэн өөрчлөх

2000 оны 9 сард УТЕГ-аас гаргасан хуулийн төсөлд хуучин байсан 38 нэр төрлийн ажил үйлчилгээн дээр шинээр авто машины зогсоолын үйлчилгээ, барьцаат зээлдүүлгийн үйлчилгээ, үүрэн телефоны худалдаа гэх мэт 30 гаруй нэр төрлийн ажил үйлчилгээг нэмж, хуучин байсан ажил үйлчилгээнээс их хэмжээний орлого олдог 8 нэр төрлийн ажил үйлчилгээнд ногдох татварын тогтмол хэмжээг 1.2-оос 8.3 дахин нэмэхээр болжээ.

Энэхүү санал нь орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэдийн орлогод албан татвар ногдуулах тухай хуульд заасан ажил үйлчилгээний хүрээг өргөтгөж, өнөөгийн бодит байдалд нийцүүлэн татварын тогтмол хэмжээг өндөр тогтоох гэсэн санаа агуулж буй бөгөөд энэ нь хэрэгжилтийн талын амар байдал, татварын орлогын түр хугацааны өсөлтийг хангахыг зорьж буй хэдий ч татварыг үнэн зөв, эрх тэгшээр ногдуулах гэсэн татвараа өөрөө тодорхойлох системийн үндсэн зорилгоос гажиж буй тул тийм ч зохистой санал гэж үзэхгүй байна.

- 2) Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэдийн орлогод албан татвар ногдуулах тухай хуульд заасан ажил үйлчилгээний нэр төрлийг цөөлж, үлдсэн нэр төрлийн жишиг татварыг бодит байдалд нийцүүлэн өсгөх

Энэ нь аль болохоор хувиараа аж ахуй эрхлэгчдийн санхүүгийн бүртгэлд тусгагдсан үйл ажиллагааны орлого зарлагын бодит үзүүлэлтээр төлөх татварын хэмжээг тогтоох гэсэн санаа агуулж буй бөгөөд энэ нь татвараа өөрөө тодорхойлох системийн үндсэн зорилгоос авч үзвэл тохиромжтой арга юм.

- 3) Энэхүү санал нь орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэдийн орлогод албан татвар ногдуулах тухай хуулинд өөрчлөлт оруулж, хүн амын орлогын албан татварын хуулийн дагуу татвар ногдуулах гэсэн санал бөгөөд одоогийн патентын татварт хамрагдах ажил үйлчилгээний нэр төрөлд сар бүр жишиг татвар төлдөг хуучин хэлбэрийг хэвээр нь үлдээж, энэхүү сар бүр төлөх жишиг татварыг хүн амын орлогын албан татварын хуулийн дагуу төлөх орлогын татварын урьдчилгаа татвар болгон авч үзэж, жилийн эцэст тооцоо нийлдэг болгох

Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэдийн орлогод албан татвар ногдуулах тухай хуулийн 4-р зүйлийн 5-р хэсгийн «Албан татвар төлсөн тухай гэрчилгээнд заасан хугацааны ажил, үйлчилгээний орлогыг Хүн амын орлогын албан татварын хуулийн 10 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 6-д

заасан журмаар орлого, татвар тодорхойлох хуудсаар тооцох жилийн орлогын дүнд оруулахгүй.» гэдгийг хасч, энэхүү зүйлийн оронд «Албан татвар төлсөн тухай гэрчилгээнд заасан ажил үйлчилгээнээс олох орлогыг жилийн эцэст явуулах үйл ажиллагааны орлого зарлагын бодит үзүүлэлтэд тулгуурлан тогтоож, орлого, татвар тодорхойлох хуудсаар тооцох жилийн орлогын дүнд оруулан тооцохын хамт татварын илүү дутуу төлөлтийг тооцно.» гэж оруулах

Энэхүү санал нь ажил үйлчилгээ явуулах эрх авахын тулд сар бүр жишиг татвар төлнө гэдгээрээ одоо хэрэгжиж буй хуулийн татвар хураах хэлбэртэй адил боловч энэ жишиг татвар нь хүн амын орлогын албан татварын хуулийн дагуу тооцох жилийн орлогын татварын урьдчилгаа төлбөр бөгөөд жилийн эцэст татварын илүү дутуу төлөлтийг тооцохоор уг хуулийг өөрчлөх гэсэн санаа агуулж буй юм. Энэ өөрчлөлтөөр хүн амын орлогын албан татварын хуулийн дагуу тооцох жилийн бодит орлогод ногдуулах татварын хэмжээ нь жишиг татварын хэмжээнээс бага байвал буцаан олголт хийж, харин их бол нөхөн төлөлт хийнэ.

Ингэж өөрчиллөө ч жишиг татварын хэмжээнээс давсан орлоготой татвар төлөгч иргэн нь өөрийн сайн дураар татвараа үнэн зөв тодорхойлно гэдэг нь эргэлзээтэй бөгөөд жишгээр татвар төлөх системээс татварын тэгш шударга байдлыг хангах хүн амын орлогын албан татварын хуулийн дагуу татвар ногдуулах системд шилжих хэрэг тул үлдэх асуудал нь татварын хяналт шалгалт болон татвар хураалтыг хэр үр ашигтай явуулах боломжтой вэ гэсэн татварын үйл ажиллагааны хэрэгжилтийн асуудалтай холбогдож ирнэ.

Энд нэг чухал зүйл бол жишгээр татвар ногдуулах одоогийн системээс хүн амын орлогын албан татварын хуулийн дагуу татвар ногдуулах системд шилжих явдал бөгөөд иймээс бодит орлого нь жишиг татварын хэмжээтэй харьцуулахад үлэмж зөрүүтэй байгаа татвар төлөгчид татварын алба ямар нэгэн арга хэмжээ авч болох тухай хууль зүйн үндэслэлийг гаргаж өгөх явдал юм.

Ингэснээр жишиг татвараар татварын орлогыг доод түвшинд хангах боломж бүрдэхийн зэрэгцээ өндөр орлоготой татвар төлөгчдөд зохих татвар ногдуулахын тулд татварын алба нь өөрийн хэрэгжүүлж чадах хүрээндээ татварын хяналт шалгалтын байцаагч нарыг ажиллуулахад хангалттай. Үүний үр дүнд татвар төлөгчдийн дунд үүсэх тэгш бус байдал арилж, иргэдийн татварын албанд итгэх итгэлийг хадгалж чадах юм.

- [3] Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэдийн орлогод албан татвар ногдуулах тухай хуулийг өөрчлөлгүйгээр тайлбар оруулах замаар өндөр орлоготой татвар төлөгчид хүн амын орлогын албан татварын хуулийн дагуу татвар ногдуулах

Энэхүү санаа нь орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэдийн орлогод албан татвар ногдуулах тухай хуулинд заасны дагуу жишгээр татвар ногдуулах нь тус хуулийн батлагдан гарсан шалтгаан болон татварын эрх тэгш байдлын зарчимтай зөрчилдөх тохиолдолд тухайн ажил үйлчилгээний нэр төрөл нь тус хуулинд заасан нэр төрөлд хамаарах байлаа ч тухайн ажил үйлчилгээг орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэдийн орлогод албан татвар ногдуулах тухай хуульд заасан ажил үйлчилгээнд хамаарахгүй гэсэн тайлбар хийж өгнө гэсэн санаа юм. Ингэсэн тохиолдолд тухайн татвар төлөгчид мэдээжийн хэрэг орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэдийн орлогод албан татвар ногдуулах тухай хуулиар татвар ногдуулах боломжгүй болж, хүн амын орлогын албан татварын хуулийн дагуу татвар ногдуулах болно.

Ийм маягаар татвар ногдуулахад татвар төлөгч шүүхэд хандах тохиолдолд татварын алба нь дор дурдсан зүйлийг батлах үүрэг хүлээх болно.

- 1) Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэдийн орлогод албан татвар ногдуулах тухай хууль бий болсон шалтгаан

Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэдийн орлогод албан татвар ногдуулах тухай хуулиар орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил үйлчилгээ эрхлэгчдэд тухайн үйл ажиллагааны орлого зарлагын бодит тооцоонд тулгуурлан орлогыг нь тооцолгүй, харин тогтмол хэмжээний татвар, өөрөөр хэлбэл, жишиг татвар төлснөөр тэдний татвар төлөх үүрэг дуусгавар болдог. Энэхүү орлогыг тодорхойлох боломжгүй гэдэг нь санхүүгийн бүртгэлд тулгуурласан татварын тайланг татвар төлөгч гаргана гэж найдалтгүй гэсэн санааг л агуулж буй бөгөөд татвар төлөгчийн татварын мэдлэг боловсрол, санхүү бүртгэлийн дутуу дулимаг мэдлэг гэсэн татвар тодорхойлон тооцоолох техникийн асуудал төдий л зүйл юм.

Иймээс орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэдийн орлогод албан татвар ногдуулах тухай хуулинд ажил үйлчилгээний нэр төрлийг заахдаа тухайн ажил үйлчилгээ эрхлэгчийн орлогын хэмжээ нэг их өндөр бус, жишиг татвар ногдууллаа ч татвар ногдуулалтад нэг их сөрөг нөлөө үзүүлэхгүй тийм ажил үйлчилгээг хязгаарлан зааж өгөх хэрэгтэй.

Тухайн татвар төлөгчийн эрхлэх ажил үйлчилгээ нь бусад ижил төрлийн ажил үйлчилгээ эрхлэх татвар төлөгчийнхтэй харьцуулахад орлогын дундаж хэмжээ нь үлэмж их, мөн патентаар татвар ногдуулах нь татварын эрх тэгш ногдуулалтад ихээхэн сөрөг нөлөө үзүүлж байна гэж үзсэн тохиолдолд орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй



ажил үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэдийн орлогод албан татвар ногдуулах тухай хуулиар татвар ногдуулахгүй гэсэн тайлбар хийж болно.

2) Тухайн татвар төлөгчийн орлогыг тодорхойлох

Татварын алба нь нягтлан бодох бүртгэл болон бусад анхан шатны бүртгэлийн дагуу ажил үйлчилгээний орлого зарлагын тооцоонд үндэслэн орлогоо үнэн зөв тодорхойлох шаардлагатай. Ажил үйлчилгээний орлого зарлагын тооцоонд үндэслэн орлогыг тодорхойлох боломжгүй үед бусад адил төрлийн ажил үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгжтэй харьцуулах замаар жишгээр орлогыг тодорхойлно. Жишгээр тодорхойлох тохиолдолд орлогыг жишгээр тодорхойлох хууль зүйн үндэслэл болон аргачлалын оновчтой байдлыг баталж, татвар ногдуулалтын хуульд нийцсэн байдлыг батлах хэрэгтэй болно.

3) Орлого нь адил төрлийн үйл ажиллагаа эрхлэгчийнхтэй харьцуулахад өндөр, татварын эрх тэгш зарчмын үүднээс жишгээр татвар ногдуулах нь оновчгүй тохиолдолд

Татварын алба нь дээрх 2)-т заасны дагуу тодорхойлсон орлого нь жишгээр ногдуулах татварын орлоготой харьцуулахад үлэмж их (жишээ нь 2 дахин илүү байх гэх мэт) болохыг баталж, татварын эрх тэгш зарчмыг хангах үүднээс орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэдийн орлогод албан татвар ногдуулах тухай хуулиар бус харин хүн амын орлогын албан татварын хуулийн дагуу татвар ногдуулах нь хуульд нийцнэ гэдгийг баталж өгөх хэрэгтэй болно.

### 5.3 Цаашид судалж үзэх чиглэл

Орлогыг тухай бүр тодорхойлох боломжгүй ажил үйлчилгээ эрхлэгчдэд татвар ногдуулах харилцааны тухай болон түүний өнөөгийн байдал, тулгамдсан асуудал, түүнийг шийдвэрлэх арга замын тухай дээр авч үзлээ. Өнөөгийн татварын хэрэгжилтийн онцлог байдлаас харвал, цаашид дараах чиглэлээр өөрчлөлтийг дэс дараатайгаар авч хэрэгжүүлэн, орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэдийн орлогод албан татвар ногдуулах тухай хуулийг бүхэлд нь халж, хүн амын орлогын албан татварын хуулийн дагуу татвар ногдуулдаг болгох нь зүйтэй.

- 1) Ажил үйлчилгээний нэр төрлийг цөөрүүлж, үлдсэн нэр төрлийн хувьд жишиг татварын хэмжээг өнөөгийн бодит байдалд нийцүүлэн өөрчлөх (5.2[2]2)-д бичсэн арга)
- 2) Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэдийн орлогод албан татвар ногдуулах тухай хуулийн үндсэн зорилго болон татварын эрх тэгш зарчмыг хангах үүднээс өндөр орлого бүхий татвар төлөгчид орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэдийн орлогод албан татвар ногдуулах тухай хуулиар бус, хүн амын орлогын албан татварын хуулийн дагуу татвар ногдуулахаар өөрчлөх. Шүүхээр заргаа алдсан ч татварын ногдлын тэгш бус байдлыг илэрхий болгосноор орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил үйлчилгээ хувиараа эрхлэгч иргэдийн орлогод албан татвар ногдуулах тухай хуулийг өөрчлөх үндэслэлийг тавьж өгөх болно. (5.2[3]-д заасан арга)
- 3) Тогтмол хэмжээний татварыг жилийн татварын урьдчилгаа төлбөр болгож, жилийн эцэст татварын илүү дутуу төлөлтийг тооцохоор өөрчлөх. (5.2[2]3)-д заасан арга)

## Бүлэг 6



## 6. Татварын нягтлан бодох бүртгэлийн систем

### 6.1 Татварын нягтлан бодох бүртгэл

#### 6.1.1 Өнөөгийн байдал ба тулгарч буй бэрхшээлтэй асуудлууд

##### [1] Өнөөгийн байдал

Татварын хууль тогтоомжийн дагуу татвар ногдуулах орлогыг тооцохын тулд хөтөлж буй бүртгэлийг татварын нягтлан бодох бүртгэл гэдэг. 1990 оны эх (Эдийн засгийн шинэчлэлээс өмнө)-ээр Монгол улсад татварын нягтлан бодох бүртгэлийн систем гэж байгаагүй бөгөөд нягтлан бодох бүртгэл нь анхан шатны тоо баримт дээр үндэслэгдэн боловсруулагдаж байв.

Зах зээлийн эдийн засгийн шилжилт эхэлсэн 1992 оноос хойш Монгол улсын засгийн газар татварын системийн шинэчлэлт хийж, 1993 онд нягтлан бодох бүртгэлийн шинэ хуулийг гаргах зэргээр цогц өөрчлөлтийг хийжээ. Энэхүү татварын шинэ системийг нэвтрүүлснээр татвар төлөгч татварын төрөл бүрээр татварын тайлан гаргах үүрэг хүлээхийн зэрэгцээ зөвхөн татвар төлөгчид төдийгүй татвар хураах байгууллага болох татварын албанд ч татварын нягтлан бодох бүртгэлд суралцах хэрэгцээ шаардлага гарч ирсэн байна.

ҮТЕГ нь мэдээлэл боловсруулалтад тавигдах шаардлагыг хангах үүднээс татвар төлөгчөөс ирүүлсэн тайлангийн чанар, тайлан гаргах үүргээ биелүүлэхтэй холбогдсон асуудалд бүх анхаарлаа хандуулан ажиллаж байгаа билээ.

Монгол улсын засгийн газар 1994 онд олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартад тулгуурласан нягтлан бодох бүртгэлийн системийг нэвтрүүлж, аж ахуйн нэгж байгууллагуудад аккурал зарчмын дагуу санхүүгийн тайлан гаргах үүрэг хүлээлгэжээ. Гэвч татварын тайлан гаргах зарчим тодорхой бус, түүнийг гаргах үед ямар санхүүгийн системийг хэрэглэх талаарх заалт татварын хуулиудад заагдаагүй. Энэ мэт шалтгаанаас үүдэн ҮТЕГ-ын тухайн хариуцагч ажилтнууд аккурал зарчмаар бус, зарим тохиолдолд мөнгөн суурьт зарчмаар татварын тайлан гаргахыг шаардах тохиолдол байдаг. Улмаар татварын алба болон татвар төлөгчийн аль алиных нь татварын нягтлан бодох бүртгэл, санхүүгийн нягтлан бодох бүртгэлийн ялгаа заагийн талаарх мэдлэг хангалтгүй байдаг. Татварын албаны ажилтны 2/3 нь төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн үед боловсрол эзэмшсэн бөгөөд олон жил бүртгэлийн хуучин системээр ажлаа явуулж ирсэн бол үүний нөгөө талд шинээр ажилд орогсод харьцангуй шинэ мэдлэг эзэмшсэн байх жишээтэй. Иймээс тэд нарын дунд зөрчилдөөн, үл ойлголцох байдал үүсэх тохиолдол ч гардаг. ҮТЕГ энэхүү асуудлыг шийдвэрлэх гол арга зам бол татварын хуулинд бүртгэл болон бүртгэлийн системийн талаар тодорхой заах, мөн тус тусын холбогдох хуулинд татварын бүртгэл, санхүүгийн бүртгэлийн талаарх холбогдох заалтыг тусгах явдал юм гэж үзэж байна. Өөрөөр хэлбэл, санхүүгийн

бүртгэлийг нягтлан бодох бүртгэлийн хууль, татварын бүртгэлийг татварын хуулинд тус тус тусгах нь тодорхой боловч өнөөгийн Монгол улсад энэ талаар ямар ч арга хэмжээ аваагүй байгаа тул энэхүү асуудлыг шийдвэрлэж чадахгүй байсаар байна.

Нөгөөтэйгүүр, татвар төлөгчийн нягтлан бодох бүртгэлийн холбогдолтой мэдлэг тухайн эрхэлж буй үйл ажиллагаанаасаа хамаараад ялгаатай байдаг. Том аж аж ахуйн нэгжүүдийн хувьд нягтлан бодогч нарын дунд мэргэшсэн нягтлан бодогчийн зэрэгтэй хүн ч байх бөгөөд нийт компанийн бүртгэлийн асуудлыг бүрэн шийдчих чадвартай байдаг бол жижиг салбар компаниудын бүртгэл тооцоо хариуцагчийн нягтлан бодох бүртгэлийн талаарх мэдлэг хангалттай гэж хэлж чадахгүй юм. Бодит амьдрал дээр гол болон салбар компанийн бүртгэлийн систем гэж байдаггүй. Мөн нягтлан бодогч цөөтэй жижиг дунд үйлдвэрийн хувьд тэдний мэдлэг чадвар ялгаатай байдаг.

## [2] Бэрхшээлтэй асуудлууд

Өнөөгийн татварын албаны бүтэц зохион байгуулалтаар ногдуулалтын байцаагч нар татвар ногдуулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлдэг. Тус алба нь тушаагдсан татварын болон санхүүгийн тайлан, бусад баримт бичгийг шалгаж, татвар төлөгчтэй хэлэлцсэний үндсэн дээр татвар ногдох орлогыг тогтоодог. Татварын алба нь тайлагнасан орлого, зардлын дүнг тодорхойлохын тулд тушаагдсан бүх баримт бичгийг сайтар шалгадаг. Баримт бичгийн агуулгад илт алдаа байх тохиолдолд татвар төлөгчийн зүгээс түүнд ямар нэгэн засвар оруулагүй бол тайлант хугацаа дууссаны дараа дахин татвар ногдуулдаг. Татвар төлөгчийн тушаасан бүх тайлан татварын албаны дахин шалгалтанд хамрагдах бөгөөд шаардлагатай тохиолдолд дахин татвар ногдуулалт хийгдэнэ. Энэхүү дахин татвар ногдуулалтын явцад үүсдэг асуудлуудаас чухал гэж үзсэн зарим нэгийг нь дор дурдъя.

- 1) Улирлын явц дахь татварын дахин тооцолтоор улам их асуудал үүсч болзошгүй. Татварын тайланг өссөн дүнд тулгуурлан гаргадаг тул татвар төлөгч дараагийн улиралд өөрөө зөрүү дүнг засварлах тохиолдол гарч ирж болох бөгөөд энэ нь татварыг давхардуулан тооцох явдалд хүргэж болзошгүй. Эдгээр нь жилийн эцсийн татварын хяналт шалгалтаар илрэх тохиолдол ч байдаг. Энэхүү алдаа бүхий дахин татвар ногдуулалт нь татварын хяналт шалгалтын дүнтэй эцсийн дүндээ зөрчилдөнө.
- 2) Аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татварын тайлан болон НӨТ-ын тайлан нь өөр өөрийн зорилготой ялгаатай билээ. НӨТ-ын тайланг сар бүр тушаадаг бөгөөд орлогын албан татварынхтай тулган шалгах тохиолдол олон. Гэхдээ тайлагнасан борлуулалтын дүн тохирохгүй, хоорондоо зөрөх нь олонтаа байдаг. Ерөнхийдөө НӨТ-ын тайлангаар тайлагнасан борлуулалтын дүн зөв боловч НӨТ, орлогын албан татварын тайлангийн борлуулалтын зөрүү дүнг тохируулахын тулд татварын хяналт шалгалт хийгч бичгээр тайлан гаргадаг. Нарийн тодорхойлж хэлбэл, НӨТ болон орлогын албан татварын тайлангийн дүн

зөрөөгүй ч тайлан гаргах ёстой бөгөөд татварын хяналт шалгалтын байцаагч нь хоёр тайлангийн зөрүүг зохицуулахын тулд зөвлөмж гаргах ёстой болдог. Татвар ногдох дүн өссөн тохиолдолд зөвлөмж гаргадаг бөгөөд энэ нь орлогын албан татвар болон НӨТ-ын хоорондын зөрүүг арилгах бус харин зөрчил бүхий тайлан гаргасан татвар төлөгчдөд хариуцлагаас зайлсхийх боломжийг олгож өгч байна.

- 3) Татвар төлөгч нь татварын тайлан гаргадагтай адил ангиллын дагуу орлогын тайлан гаргах ёстой. Гэхдээ татвараас зайлсхийхийн тулд татварын хөнгөлөлт эдлэх тодорхой нэг орлогыг туслах орлого маягаар орлогын тайланд бүртгэж, татвар ногдох орлогыг багасгаж тайлагнах тохиолдол байдаг. Татвар ногдуулах явцад түүнд ашиглаж буй тоо баримт нь үнэн зөв үү гэдгийг тогтоох нь хэцүү зүйл. Тухайлбал, татвар төлөгч гаалийн татварыг багаар тайлагнахын тулд нэхэмлэхийн дүнг худал бичиж, орлогын албан татварын дүнг бууруулахын тулд өндөр дүнтэй нэхэмжлэх хэрэглэж, зардлаа өсгөж, татвар ногдуулах орлогоо бууруулдаг. Энэ мэт тохиолдлууд нь бүгд татварын алба, гаалийн байгууллагын хоорондын хамтын ажиллагааны сул талыг ашиглах замаар татвар төлөгчийн хийдэг үйлдэл бөгөөд анхан шатны баримт бичгийн нэгдмэл бус байдал нь татвар ногдуулалт болон татварын хяналт шалгалт хийх үед тэдгээрт хийх тулган шалгалтанд ихээхэн төвөг учруулж байна.

Санхүүгийн төвөгтэй бүртгэл, татварын алба болон гаалийн байгууллагын хоорондын мэдээлэл солилцооны тал дээрх хамтын ажиллагааны сул талыг ашиглан татвар төлөгч өөр өөр дүн бүхий нэхэмжлэх ашиглан тайлан гаргаж, татвар төлөгчийн дугаараар баталгаажуулахгүй анхан шатны баримт бичгийг ашиглаж байна. Иймээс энэхүү тохиолдолд дахин татвар ногдуулалт нь ихээхэн чухал үүрэг гүйцэтгэнэ. Гэхдээ одоогийн татварын албанд явуулж буй дахин татвар ногдуулалт нь татвар ногдуулалтын хэсэг болон татварын хяналт шалгалтын хэсэг хоёрын хоорондын үйл ажиллагаанд зөрөлдөөн бий болгож болно. Татвар ногдуулалтын хэсгийн хяналтын байцаагч татварын тайлан хүлээн авах үедээ дахин татвар ногдуулалт хийнэ гэж үзэн зөвлөмж гаргах нь хяналт шалгалтын байцаагчийн үүрэг хариуцлагын хүрээг хумьж байгаа мэт санагдаж байна. Харин зөвлөмж гаргахгүй тохиолдолд ажлын үүрэг хариуцлага биелүүлэхгүй байна гэж үзэж болно.

Татвар төлөгч нь татварын хуулийн дагуу тухайн татварын албанаас тавигдаж буй шаардлагад тулгуурлан хийгдсэн орлогын тайлангийн дагуу татварын тайлан гаргах тул залруулга тайлан гаргах шаардлага буй эсэхийг огт мэдэрдэггүй. Энэ нь олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтлөлт Монгол улсад хэвшээгүй байгаа болон хяналтын тогтолцооны хангалтгүй байдалтай холбоотой болов уу. Аймаг, хот, дүүргийн татварын албад нь харилцагч аж ахуйн нэгж байгууллагаас санхүүгийн тайлан авдаг бөгөөд бодит санхүү бүртгэлийн стандартад тохирсон бүртгэл хөтлөлт, санхүүгийн тайлан гаргах зэргийг шаардаж хэвшээгүй байна. Мөн аж ахуйн нэгж байгууллагын ихэнх нь бүртгэлээ санхүү бүртгэлийн стандартын дагуу хөтөлж, санхүү бүртгэлд

тулгуурлан үйл ажиллагааны анализ хийх явдалд нэг их ач холбогдол өгдөггүй.

Өнөөгийн байдлаар татвар төлөгчид нийтдээ 18 төрлийн татварын тайлан гаргадаг. Үүнд тулгуурлан мэдээлэл статистикийн хэлтэс нь 45 төрлийн статистикийн баримт материал гаргадаг. Энэ үед гол татварын төрлүүдээр гаргах татварын бүртгэлийг товч авч үзвэл дараах байдалтай байна.

#### Аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татвар

Одоогийн байдлаар аж ахуйн нэгж байгууллага нь татварын тайлан гаргаж, борлуулалтын дэвтэр, орлогын тайлан болон түүнтэй холбогдох ажил гүйлгээний бүртгэл журналыг ашиглан хасагдах зардал болон өрийг тооцож гаргадаг. Гэхдээ татвар төлөгчийн олонхид санхүү бүртгэл хөтлөлт, анхан шатны баримт бичгийн цуглуулалт хэвшээгүй бөгөөд энэ нь татварын тайлангийн үнэн зөв байдалд сөрөг нөлөө үзүүлж байна. Мөн олон улсын бүртгэлийн стандартаарх бүртгэл, Монгол улсын татварын хуулиар тавигдах шаардлагаарх бүртгэл хоёрын хооронд зөрчил гардаг бөгөөд санхүүгийн бүртгэлийн зарим хэсэг нь татварын бүртгэлд ашиглагдах тул зарим зохицуулалт хийх шаардлагатай байдаг. Эдгээртэй холбогдон аж ахуйн нэгж байгууллагууд татварын тайлан гаргах үед ч бэрхшээл гардаг. Татвар төлөгч нь татвар ногдох орлогыг тооцож гаргахдаа «санхүүгийн тайлан болон татварын тайлангийн зөрүүг зохицуулах тайлан» дээрх цэвэр ашгийг удирдлагын бүртгэл болон өртгийн тооцоонд тулгуурлан татвар ногдох орлогыг дахин тооцоолон гаргахаас төвөгшөөх, эсхүл эдгээрийг хийдэг байлаа ч үнэн зөв тооцоог хийдэггүй. Зөрүүг зохицуулах аргын талаарх зөв мэдлэг, татвар төлөгч болон зарим татварын байцаагч нар үүний чухал хэрэгцээ шаардлагын талаар дутуу дулимаг ойлголттой байдгаас үнэн зөв тайлан гаргадаггүй. Эдгээр нь зөрүү дүнгийн дахин тооцоолол нь зөрүүг засварлах тайланг бүрэн хамраагүй, аж ахуйн нэгж байгууллага татварын тооцоо хийхдээ шаардлагатай өргөн хүрээний бүртгэл материалыг ашигладаггүй, эсхүл энэхүү тайлан нь аж ахуйн нэгж байгууллагын татварын тайлантай холбоогүй байдаг зэрэгтэй ч бас холбоотой болов уу.

#### Хүн амын орлогын албан татвар

Хүн амын орлогын албан татварын хуулийн дагуу цалин олгох этгээд нь хуваарилагдан олгогдох орлогоос татварт хамаарах хэсгийг суутган үлдээж, суутгалын татварын тайлан тушаадаг. Тайлан гаргахад цалингийн тодруулга, кассын дэвтэр, бусад бичиг баримт шаардагддаг.

Хувиараа аж ахуй эрхлэгч иргэн өөрийн орлого болон түүнд ногдох татварын хэмжээг тодорхойлж, орлого татвар тодорхойлох хуудсаа тушаах ёстой бөгөөд татварын алба нь тэр бүр татвар төлөгчөөр энэхүү үүргийг мөрдүүлж чаддаггүй. Мөрдүүлж чадаж байлаа ч татвар ногдох орлогын тооцоог хийх тооцооллын аргыг ойлгодог татвар төлөгч цөөхөн. Энэ нь татвар төлөгчийн боловсрол одоогоороо хангалтгүй байгаатай холбоотой бөгөөд иймээс удирдамж, материал гаргах замаар татварын боловсрол, зар суртчилгааны ажлыг өргөжүүлэх шаардлагатай.



Цалин олгогч этгээд нь суутган авсан татварын дүнг татварын албанд заасан хугацаанд тушааж, дараа сарын 10-ны дотор сарын татварын тайлангаа тушаах ёстой. Хувиараа аж ахуй эрхлэгч нь хялбарчилсан бүртгэл хөтөлж, улирал бүрээр татвар ногдох орлогоо тооцон гаргаж, улирал дууссаны дараагийн сарын 15-ны дотор татвараа төлөх ёстой. Мөн татвар төлөгч иргэн нь жилийн албан татварыг дараа оны 2 сарын 10-ны дотор тооцон гаргасан байх ёстой байдаг. Гэхдээ хувиараа аж ахуй эрхлэгч иргэн нь үүний дагуу татвараа төлөх нь ховор бөгөөд тэдний ихэнх нь «Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил үйлчилгээ эрхлэгч иргэдэд татвар ногдуулах тухай хууль»-ийн дагуу ажил үйлчилгээний төрөл тус бүрээр заасан тогтсон хэмжээний татварыг сар бүр төлж, олж буй орлоготой нь харьцуулахад бага хэмжээний татвар төлөөд л татвар төлөх үүргээс чөлөөлөгдөж байна. Энэхүү хууль оршин тогтнож байгаа нь аж ахуйн нэгж байгууллагуудад эрх тэгш бус байдал үүсгэж байгаа билээ. Иймээс ч цөөнгүй аж ахуйн нэгж байгууллага энэхүү бага хэмжээний татварт хамрагдахын тулд аж ахуйн нэгжээ татан буулгах тохиолдол гарч байжээ. Татварын орлогын үүднээс ч авч үзсэн энэ нь ихээхэн бэрхшээл авчирч буйг энд хэлэх хэрэгтэй.

#### Нэмэгдсэнөртгийн албан татвар (НӨТ)

НӨТ-ын татвар төлөгч нь бүх ажил гүйлгээгээ анхан шатны баримт бичгээр баталгаажуулах ёстой бөгөөд борлуулалтаа тооцох бүрдээ НӨТ-ын дүнг тусгасан нэхэмжлэх гаргадаг. Татвар төлөгч нь НӨТ-ын тооцоо хийхдээ борлуулалт болон худалдан авалтын дэвтэр хөтөлж, түүнд бичигдсэн бүх ажил гүйлгээг НӨТ төлөгдөх, чөлөөлөгдөх, экспорт импортын гэх мэтээр ангилах ёстой. Ингээд НӨТ-ын татвар төлөгч нь бараа болон ажил үйлчилгээний борлуулалтад ногдох НӨТ-ыг дараа сарын 15-ны дотор төлөх ёстой байдаг. Мөн импортын бараанд татвар ногдуулах, хураан авах ажил нь гаалийн байгууллага болон тухайн татварын албаны хариуцах ажил бөгөөд сар бүрийн татварын тайланг дараа сарын 10-ны дотор, жилийн татварын тайланг дараа оны 1 сарын 15-ны дотор сангийн яаманд тушаах ёстой байдаг.

Харин хувиараа аж ахуй эрхлэгч иргэдийн хувьд борлуулалт нь тодорхой бус тул «Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил үйлчилгээ эрхлэгч иргэдэд татвар ногдуулах тухай хууль»-ийн дагуу НӨТ огт төлөгддөггүй.

Татварын нягтлан бодох бүртгэлийн асуудлын хувьд татвар төлөгчдөд боловсрол олгох шаардлагатай. Татварын ажил урагштай явахгүй байгаа нэг шалтгаан нь татвар төлөгчдийн нягтлан бодох бүртгэлийн мэдлэг дутмагтай холбоотой. Мөн зөвхөн татвар төлөгчийг бус татварын албаны байр суурийг ч бас харгалзан үзэх шаардлагатай. Иймээс Монгол улсын татварын албанд санхүү бүртгэлийн системийг нэвтрүүлэх шаардлага тулгарч ирээд байгаа бөгөөд татварын албаны удирдлага бүтцийг бэхжүүлэх, удирдлагын чадварыг сайжруулах, татвар хураалтын тогтолцооны шинэчлэлтийг урт хугацаанд хийх шаардлага тавигдаж байна.